

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга		
Хуралдааны товч тэмдэглэл:		1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:		4-27

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025.11.20-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

4-27

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
4 дүгээр сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Баярбаатар, Э.Болормаа, Ц.Даваасүрэн, Ч.Номин, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар.

Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, С.Эрдэнэболд, С.Зулпхар, Ж.Батжаргал, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, С.Эрдэнэболд, С.Бямбацогт, О.Алтангэрэл, С.Зулпхар, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, А.Ариунзаяа, О.Батнайрамдал, Д.Энхтүвшин, П.Сайнзориг нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 4
Бүгд: 23
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 87.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 82.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 82.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 82.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
9 цаг 11 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/-ны 2026 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Жадамбын Бат-Эрдэнэ, Жигжидийн Батжаргал, Сандагийн Бямбацогт, Лувсаннъямын Гантөмөр, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Лхагвын Мөнхбаатар, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа, Батын Батбаатар нарын гишүүд ирж, хуралдааны ирц 56,3 хувьтай байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэхийг хийнэ. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хийнэ. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: ТББХ-ны дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөө цагт парламентын спикер төв ч, бие даасан байр сууриас парламентын хуралдааныг удирдах нь парламентын ардчилал, парламентын дархлааны салшгүй гол зарчим болсон байна. Дэлхий нийтийн нийтлэг хандлагаар парламентын нийтийн танхимыг олон намын тогтолцоо, олон ургалч байдал бүхий чөлөөт хэлэлцүүлгийн орчин, олонх цөөнхийн бодлогын мэтгэлцээний талбар, улс төрийн зөвшил, ойлголцлын механизмаас гадна нээлттэй хяналттай төрийн үйл ажиллагаа иргэний мэдэх эрхийн гол эх үүсвэр болох нь парламентын спикер, түүнд тавигдах шаардлага, түүний томилгоо, чөлөөлөлттэй шууд холбоотой гэж үзэж байна.

2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоотой болсон төдийгүй

парламентын давжаа байдлыг засаж, 126 түвшинтэй болсон. Үүний үр дүнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар УИХ 4 нам, 1 эвсэл суудал авч олон намаас бүрдсэн Улсын Их Хурал олонх, цөөнхийн байр сууриас намын лидерүүд нь мэтгэлцэж, зөвшилцдөг парламентын ардчиллын тулгуур зарчим Монгол Улсад төлөвшиж хөгжих боломж нэмэгджээ. 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн өөрчлөлтөөр УИХ асуулгын цагтай болж Ерөнхий сайд сөрөг хүчний лидер бодлогын мэтгэлцээн хийдэг, гишүүд цаг үеийн асуудлаар Ерөнхий сайдаас шууд асууж, хариулт авдаг улс төрийн шинэ соёл бий болсон билээ.

Улсын Их Хурлын даргын давхар ажил эрхлэлттэй холбоотой хязгаарлалтыг тодорхой болгохгүй бол парламентын ардчиллын олон улсын жишгийн дагуу парламентын спикер төвийг сахиж, хуралдааныг удирдах, олонх цөөнхийн мэтгэлцээнийг хөндлөнгийн байр сууриас явуулах, олонхын шийдвэр гаргах, цөөнхийн хяналт тавих эрхийг баталгаажуулах болон олон намын үзэл баримтлал бодлогын өрсөлдөөнийг УИХ-д хэрэгжүүлэх явдлыг алдагдуулах эрсдэлтэй байна. Мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын нийт гишүүдийн 1/4-ээс доошгүй нь хуулийн өөрчлөлт биелэлтийг хангахтай холбоотой, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал УИХ цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулах тухай шинэ зохицуулалт парламентын хяналтын шинэ механизм бий болгосон.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт ээлжит чуулганы хугацаанд 2 хүртэл Хянан шалгах түр хороо ажиллахаар заасан нь парламентын хяналт шалгалтын үйл ажиллагааг доголдуулсан төдийгүй нийтийн ашиг сонирхол хөндсөн тодорхой асуудал дээр УИХ ажиллаж чаддаггүй, олон нийтийн дуу хоолойг сонсдоггүй, нийгмийн төлөө санаа зовох хүсэл зориггүй, Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй гэж иргэд, олон нийт үнэлэх, дүгнэх үр дагавартай байна. Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилсан болно.

Хуулийн төслийн зорилго нь Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын нийт бүрэлдэхүүний олонхонд хүлээн зөвшөөрөгдөх, төвийг сахисан байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын хуралдааныг сонирхлын зөрчилгүй, намчирхалгүй удирдах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн түр эзгүйд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Үндсэн хуулийн шаардлага, нөхцөлийг ханган хэрэгжүүлэх зэрэг асуудлыг зохицуулах хууль зүйн үндсийг бий болгох төдийгүй нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах ажлыг үр нөлөөтэй, зүй бус хязгаарлалтгүй хэрэгжүүлэх боломжийг олгоход чиглэнэ. Хуулийн төсөл батдагдсаар Монгол Улсад парламентын ардчилал бэхжих, улс төрийн намууд хариуцлагажих, хуулийн биелэлт, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар УИХ Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль зүйн боломж нэмэгдэнэ.

Хуулийн төслөөс 3 ба түүнээс дээш хяналт шалгалтын түр хороо байгуулагдах хууль зүйн боломжийг нээж байгаа учир Түр хорооны дотоод зохион байгуулалттай холбогдох гарах зардлыг Түр хороонд орсон гишүүдийн төсвөөс санхүүжүүлэх талаар зохицуулалтыг уялдуулан боловсрууллаа. Хуулийн төслийн дагуу үүсэж болох үр дагавартай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа. Хууль санаачлагч.

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Батын Батбаатар гишүүнээр тасаллаа. Ирцээрээ Гантөмөр гишүүн асуултаа асууя.

Л.Гантөмөр: Энэ асуудал асар чухал байгаа юм. Ер нь бид парламент нь парламент шиг болоод, Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгч шиг болоод, Засгийн газар /ЗГ/ нь ЗГ шиг болох зайлшгүй шаардлага байгаа, бүлэг нь бүлэг шиг. Байр байрандаа очихгүй бол хэдүүлээ Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараа яаран сандраад Дэгийн хуулиа хийчихсэн. Ерөнхийлөгчийн хуулиа одоо хүртэл батлаагүй ингээд байж байдаг. Тэгээд ЗГ-ын хууль бас нэг бантан шиг юм байдаг, болох, болохгүй асуудлыг ЗГ Их Хурал руугаа оруулж ирдэг. Их Хурал нь одоо яг юу шийдэх вэ гэдгээ их тодорхой гаргаад, гаргаж байгаа шийдвэр нь Монгол Улсад хэлбэрэлтгүйгээр мөрдөгддөг болох энэ бол одоо төрийн дархлаанд асар чухал байгаа юм.

Тэгээд би Бямбацогт даргаас нэг зүйлийг тодруулаад, Тэмүүжин гишүүнээс давхар асууя гэж бодож байгаа юм. Хулхиддаг тийм ээ? Одоо ер нь хулхидаад бол нам дотроо ч хулхидаж л байдаг бид, нам дамнаж хулхидаж байдаг, хаширч байна. Тэгээд ер нь бид энэ үнэт зүйл дээрээ бол нэгнийгээ хулхидмааргүй байгаа юм. Үнэт зүйл дээрээ. Юу вэ гэхлээр өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал парламентын үнэт зүйл, энэ бол зарчим. Тэгэхээр би Их Хурлын удирдлагууд Сандаг-Очир дарга байна, Бямбацогт дарга Их Хурлын дарга болох байх, Батжаргал дарга байна Ардын намын бүлгийн дарга, хууль санаачлагч Тэмүүжин байна. Та нар ер нь ирэх 7 хоногт яг энэ хуулийг батлах уу? Гадна, дотнын нөлөө ороод ирлээ, энд тэндхийн дарамт шахалт ороод ирлээ, бүлгийн гишүүд эсрэг байна энэ тэр гээд ингээд бултаж гуйваад энэ зарчим болоод итгэл үнэмшил дээрээ нэгнийгээ хулхидаад байвал Монгол төрийн нэр хүнд унах гэхээсээ илүү Монгол төрийн дархлаа сулраад байгаа юм л даа.

Тэгээд энэ дээр одоо та 4 бол их тодорхой хэлмээр байна, тодорхой байр сууриа илэрхийлмээр байна. Нэг эр хүн шиг байхгүй бол алхаад л буруутаад байна шүү дээ бид. Тэгээд Тэмүүжин гишүүнээс асуумаар байна. Яг энэ хуулиа батлуулах танд эр зориг болоод яг энэ ойлголцол чинь бүрэн явсан уу гэдгээ бидэнд 1 дүгээрт хэлмээр байна. 2 дугаарт ер нь Сандаг-Очир дарга энэ дэгийн асуудлаа ойрын үед нэг багцалж ярих уу? Яг 126-тай энэ парламентын дэг. Ялангуяа тэр ЗГ-ыг томилох, чөлөөлөхтэй холбоотой гээд энэ асуудлууд чинь их олон байна шүү дээ. Хэрхэн хүн үгээ хэлэх вэ, жишээлбэл бүлгүүд яаж асуулт асуух хүнээ яаж шалгаруулах вэ энэ тэр гэдгийг тодорхой зааж өгөхгүй.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагч Тэмүүжин гишүүн. Дэгээрээ хууль санаачлагч.

Х.Тэмүүжин: Бид ер нь би хувь хүнийхээ байр суурийг илэрхийлэхэд энэ парламентын ардчиллыг бэхжүүлэх, парламентын дархлааг сайжруулах чиглэлд энэ Улсын Их Хурлын чиглэлээр өргөн барьсан хуулиудынхаа эцсийг үзнэ гэдэг хатуу байр суурьтай байгаа. Ямар ч байсан УИХ-аар хэлэлцүүлнэ, УИХ-аар батлах эсэх гишүүдийн 126 гишүүний бүрэн эрхийн асуудал. Гэхдээ 126 гишүүн ер нь энэ парламентыг одоо парламент шиг болгож авахгүй бол 1992 оны Үндсэн хуулиар

бэхэжсэн Улсын Их Хурал гэдэг энэ институц өөрөө маш эмзэг, салхи дагаж намирдаг, энэ бие даасан тусгаар улсынхаа ингээд хөдөлшгүй ноён нуруу нь болоод уул шиг дүнхийгээд байж байх ёстой институц сүүлийн 2 жилийн дотор жишээ нь нэг намын дотоод сонгуулийн үр дүнгээс болоод 2 спикерээ одоо унагачхаад сууж байна шүү дээ.

Уул нь намын дотоод сонгууль болдгоороо болж л байдаг, Засаг хөдөлдгөөрөө хөдөлж шинэчлэгдэж л байдаг, УИХ тогтвортой дүнхийгээд, ноён нуруутай сууж байх ёстой байхгүй юу. Гэтэл харамсалтай нь юу болоод хувирсан бэ гэхээр Улсын Их Хурлын дарга буюу парламентын спикер өөрөө намын дотоод улс төр дотор гол тоглогч байдаг, намын дарга болох гэж оролддог, намын дарга болсон гэдэг энэ 2 үзүүлэлт чинь л өнөөдөр Монголын түүхэнд хоёрхон жилийн дотор Улсын Их Хурлын даргаа 2 удаа буулгачихсан парламентыг бий болгочхож байгаа байхгүй юу. Тийм учраас энэ хуулийн хамгийн гол үзэл санаа ерөөсөө нам парламентын спикер төвч байх ёстой, төвч байхын тулд улс төрийн намын дотоод улс төрөөс ангид байх ёстой гэдэг зарчмыг бид хуульчлахаас өөр аргагүй байна.

Намын улс төр лүү оролцдоггүй, харин намуудыг парламент дотроо мэтгэлцүүлж, ярилцуулж, зөвшлийг нь хангаж, парламентыг өөрийг нь нэг тулхтай, энэ улс орны асуудал нөгөө жоомоо алах гээд гэрээ шатаав гэдэг шиг болохгүй байхад нь гол хэрэгсэл нь болоод сууж байдаг спикертэй байх гэдэг Монгол Улсын хувьд бараг тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын нэг том хэмжүүр. Парламентын засаглал бүхий улс орнуудын бүрэн эрхт байдал гэдэг нэг ойлголт байдаг с... Энэ бүрэн эрхт байдал парламентын шийдвэр гаргах чадвар, тогтвортой байдлаар хэмжигддэг. Одоо бид парламентын тогтвортой болон шийдвэр гаргах чадвараа нэг анхаарч харахгүй бол Монгол Улсын с... чинь ер нь эмзэг байна шүү үнэнийг хэлэхэд.

Тийм учраас энэ с... буюу парламентын бие даасан байдал баталгааны гол илэрхийлэл парламентын дарга спикер. Тэгээд энэ спикерийг л одоо бид яах аргагүй парламентын засаглал бүхий Үндсэн хуультай улс орны хувьд үнэт зүйлийн нэг том шалгуур байгаад байгаа юм. Тэгээд энэ үнэт зүйл, Үндсэн хуулийн дэг журам, үзэл санаа руугаа хэдүүлээ нэг зоригтой, тууштай алхаад, энэ улс орныг нуруундаа авч явж байгаа намууд нэг ийм байр суурин дээр нэгдэх нь зөв л гэж би харж байгаа. Тийм учраас Улсын Их Хурлын даргад нэр дэвшээд, спикерийн үүргийг төвийг сахиж, парламентын ардчиллын төлөө зогсоно гэж амлалт өгч байгаа Бямбацогт гишүүн, өчигдөр байр сууриа маш тодорхой илэрхийлсэн Ардын намын бүлгийн дарга гэх мэтчилэн энэ хүмүүс одоо хэлсэн үгэндээ сууна гэж итгэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Тодруулъя Гантөмөр гишүүн.

Л.Гантөмөр: Бидэнд хамгийн чухал юм энэ итгэл үнэмшил гэдэг зүйл байгаа юм. Тийм учраас Бямбацогтоо юу яагаарай, яах вэ асуултад хариулах тийм дэггүй юм байж, үгэн дээр үг аваад, үгээ хэлээрэй. Батжаргал дарга үгээ хэлээрэй, Сандаг-Очир дарга үгээ хэлээрэй. Тэгэхгүй бол хэдүүлээ нэг ийм яасан ч яах вэ гэдэг байдлаар юманд хандаад яваад байхаар сүүлдээ энэ ард түмнээ хямраагаад байна. Тийм учраас энэ төр улсын тухайд нэг жоохон тэр нэг хэрүүл зодооноо мартаад гэхэд хаашаа юм, ямар ч байсан сэтгэл гаргахыг би та бүхнээс хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Гантөмөр даргад хэлэхэд Дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай

хуулийн нэмэлт, өөрчлөлт гэсэн 3 хуулийн нэмэлт, өөрчлөлт явж байгаа. Их Хурлын Тамгын газрын даргаас ажлын хэсэг байгуулаад бүх Байнгын хороодын ахлах зөвлөх болоод референтүүдийг оролцуулсан ажлын хэсэг ажиллаад нэлээн суусан байгаа. Нэлээн боочихсон байгаа. Ер нь яах вэ сая өргөн барья гэсэн хаврын чуулган эхлээд арай амжсангүй. Одоо ингээд асуудал үүсээд, тэгээд шинэ Их Хурлын дарга томилогдоод, санал солилцож байгаад, энэ 3 хуулийг өргөн барихад ер нь бэлэн болж байгаа.

Тэгэхээр гишүүд нам, эвсэл бүлгээрээ энэ 3 хуультай холбогдуулж санал юмнуудаа өгөхөд бэлдэж байхад, бэлдэж байгаарай. Тэртээ тэргүй нам, эвслийн бүлгээс хамтарсан ажлын хэсэг гараад явахаас хойш. Саналуудаа ер нь бэлдэж байгаарай гэдгээ хэлье. Ахиад нэг минут Гантөмөр дарга.

Л.Гантөмөр: Яг энэ Сандаг-Очир даргын хэлж байгаагаар юм явчих болов уу гэж би санаа зовоод байгаа юм л даа. Дэгийн хуулиа нэгмөсөн ярья, хийгүй сайхан юм хийе, тэгээд хойшоо тавьчихдаг, хийдэггүй, гардаггүй. Бид одоо энэ татварын бодлого, эдийн засгийн эрх чөлөөний бодлого хоёроо ерөөсөө хийхгүй байгаа шалтгаан тэр шүү дээ. Нэг мөр их гоё юм хийе л гээд байдаг. Тийм учраас Сандаг-Очир дарга тэр том бодлоготойгоо та шууд уялгүйгээр энэ хуулийг бол та батлуулах хэрэгтэй. Энэ чинь итгэл үнэмшлийн асуудал байхгүй юу. Дэгээ бол мундаг болгож байгааг би ойлгож байна. Түүн дээрээ та бүхэн бол сайн ажиллах хэрэгтэй. Энэ тусдаа шүү, та нар дэг өргөн барина, тэр үед нэгтгэж хэлэлцье энэ тэр гээд ийм сонин юм хийгээд цаг алдаад явбал итгэл үнэмшил гэдэг зүйл нураад уначихна шүү.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэмүүжин нарын 17 гишүүний тоонд нь би явж байгаа хамтран санаачлагч. Тэгэхээр яах вэ жирийн ингээд хүмүүст юу гэж ойлгогдож, ойлгуулах гэж байгаа нөхцөл байдал үүсээд байна гэхлээрээ Ардчилсан нам /АН/ ийм шантааж хийгээд байна. Тэгээд одоо ингээд намын дарга Их Хурлын дарга давхар хийж болохгүй, Их Хурлын дарга нь аль нэг намын дарга байж болохгүй эд нар гээд энэ улс төрийн энэ шахалт гэж их орчуулагдаж ойлгогдоод байгаа. Тэгэхээр Байнгын хорооны хурлын тэмдэглэлд өөрийн байр сууриа энэ дээр үлдээх ёстой гэж бодож байгаа.

Өмнө нь 2 Энхболд нэртэй хүн аль нэг намын дарга хийнгээ парламент удирдаж байсан энэ нь бол зөв жишиг биш байсан юм байна гэдэг нь субъектив хандлагаар биш ойлгомжтой болсон. Тийм учраас Монгол Улс парламентын бүгд найрамдах орон юм бол парламентад ёсоо хамгаалж, бэхжүүлж байх ёстой. Үндсэн хуулиас гадна Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.4 дээр ч гэсэн энэ парламентын засаглал нь өөрөө Монгол Улсын эрх чөлөөт байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа юм гэсэн ойлголт байгаа. Гэхдээ өдрөөс өдөрт улс төрчид нь өөрсдөө ч тэр, олон нийтийн парламентад итгэх итгэлийг унагаах ийм зүйлүүд болдог. Нөгөө талаасаа бид эдийн засгийн асуудал ярихаар л дэлхий нийтийн нөхцөл байдал, геополитикийн асуудал гэж ярьдаг хэр нь парламентын засаглалын энэ сорилттой үе дээр энийг тэр болгон эшилдэггүй.

Өнөөдөр дэлхий дахинд хүчтэй нь хүчгүйгээ гэсэн ийм ноёрхлын давлагаа явж байгаа үед Монгол Улсын энэ тусгаар тогтнолын аврал хамгийн том боломж бол нэг хүний нударга руу гулсаад орчихгүй байх энэ сэхээрэл парламентын засаглал бэхжүүлэх, энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулах зүйл гэж харж байгаа.

Энэ үүднээсээ ямар ч байсан кейс буюу нөхцөл байдлаас үүсээд дараа дараагийн нөхцөл байдал хүртэл ингээд сайжраад явж байгаа нь сайн гэж харагдаж байгаа юм. Тэгэхээр бол Тэмүүжин санаачлагчийн гишүүн хууль санаачлагчийн үг бол илүү их тийм мэргэжлийн хүмүүс рүү, хуульчид руу ойлгомжтой байдаг.

Яг ингээд би хуулийн төслийг бичсэн Тэмүүжин гишүүнээс нэг зүйлийг асуулт байдлаар хэлэх гээд байгаа нь маш энгийн, энгийн парламентын хууль батлагчид, хууль батлагчид гэхээсээ илүүтэйгээр жирийн иргэдэд зориулаад яг энэ хуулийн амин сүнс, ач холбогдлыг маш товчхоноор хэлээч. Яагаад гэхлээр өнөөдрийн болж байгаа үйл явц өрнөл дундаа дандаа улс төрийн байдлаар тайлбарлагддаг, PR-н байдлаар тайлбарлагддаг, ашиг сонирхлын байдлаар тайлбарлагддаг болчихоод байгаа үед яг одоо цаашдаа энэ магадгүй хуулийн ач холбогдол өнөөдөр харагдахгүй байсан ч гэсэн тодорхой хэд хэдэн бүрэн эрх хийн хугацааны дараа энэ бол соёл болоод, төлөвшил болоод илүү их үр дүн нь харагдах байх гэж бодож байгаа. Энэ дээр яг одоо та маш товчхон мэдээлэл өгөөч гэж хэлмээр байна. Асуумаар байна.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Би 3 өнцөг л хэлье. 1 дүгээрт нь, бид тийм дарга шүтдэг, даргад эрх мэдэл төвлөрүүлдэг тийм соёл, тийм хандлага руу бүгд уралдчихаж яг үнэнийг хэлэхэд. Сая Улсын Их Хурлын дарга буюу парламентын спикерээ 2 удаа унагах, унагасан шалтгаан ердөө энэ байна. Улсын Их Хурлын дарга хийгээд парламентын ардчиллыг манаад сууж байх ёстой хүн нь намын дарга болох гэж оролдоод л нэг нь унаж байгаа байхгүй юу. Нэг нь намын даргынхаа хажууд бас нэг даргын сэтэр зүүх гээд Улсын Их Хурлын дарга болно гэж зүтгэсээр байгаад эцэстээ дахиад унаж байгаа байхгүй юу. Тэгэхээр парламентын спикер гэдэг эрх мэдлийн төвлөрөл, даргын шуналгүй байх ёстой юм байна нэгдүгээрх нь ерөөсөө. Эрх мэдлийг өөртөө төвлөрүүлэх биш, парламентын 126 гишүүнд эрх мэдлийг задалж өгч, тэр хүмүүсийг мэтгэлцэж, шийдвэр гаргаж, энэ улс орны хөгжлийн бодлогыг ярилцах боломжийг нь олгодог тийм хүн байх ёстой юм байна. Дээлээ нимгэлж, гишүүдийг ажиллуулдаг хүн нь л спикер болох ёстой юм байна. Дээл давхарлаж өмсөж, өөрийгөө зузаалдаг биш нэгдүгээрх.

Хоёрдугаарх нь чөлөөт дуу хоолой. 92 оны Үндсэн хуулийн хамгийн чухал үзэл санаа чинь олон ургалч үзэл буюу иргэдийн дуу хоолой албан ёсны шийдвэр гаргадаг парламентад дуугарч байх ёстой. Тэгэхээр цөөнхөө боомилдог, цөөнхийн дуу хоолойг олонхын талд орж хязгаарлах гэж оролддог биш, мэдээж парламент олонхоороо шийдвэр гаргадаг. Гэхдээ тэр шийдвэрийн өмнө цөөнхөө сонсож чаддаг байх гэдэг парламентын гол мөн чанар. Тэгэхээр олонхынхоо талд ороод, цөөнхийн хуулийг хэлэлцүүлдэггүй, дуу хоолойг нь боомилдог, завсарлага авахаар зүгээр дээрээс нь хязгаар тавьж байгаад та нарт энэ л болно гэдэг нөгөө олонхынхоо дур зоргоор ажилладаг биш, зүгээр л чөлөөтэй яриулж хэлэлцүүлж юу нь үнэн зөв болох тухай энэ парламентын хэлэлцүүлэг дотроо тэнцвэртэй тавьж байгаад, дараа нь шийдвэрээ хэрсүү гаргадаг ийм парламентын боломжийг спикер л өгдөг юм байна. Тэгэхээр нэг талд ордог парламентын дарга байна гэдэг нийгмийн нөгөө талд байгаа шүүмжит өөр бодолтой тэр дуу хоолойг л хязгаарлачих гээд байдаг юм байна. Тэгэхээр энийг л үгүй хийх нэг чухал зарчим бол энэ хуулиар орж ирж байгаа.

3-д нь хамгийн чухал зүйл. Монгол Улсад намаасаа түдгэлздэг эрх мэдэл Ерөнхийлөгч байгаа. Монголын ард түмний эв нэгдлийг хангадаг Үндсэн хуулиараа. Гэтэл юу болж байна вэ гэхээр Улсын Их Хурлын дарга.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут.

Х.Тэмүүжин: Монгол Улсын Үндсэн хуулиараа Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийг түр эзгүйд орлодог. Гэтэл намаасаа түдгэлзээд, ард түмний эв нэгдлийн илэрхийлэл болох ёстой тэр албан тушаалыг нэг намын дарга, нэг намын бүр намчин хүн хэрэгжүүлбэл Монгол Улсад Үндсэн хуулийн хямрал болно. Энэ Үндсэн хуулийн хямралаас хамгаалах ганц арга зам парламентын дарга буюу Улсын Их Хурлын спикер өөрөө намчирхахгүй улс төрийн намын дотоод өрсөлдөөн болон намын үйл ажиллагаанаас ангид байх ёстой. Энэ Монгол Улсын Үндсэн хуулийн шаардлага юм билээ.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин тэргүүтэй 17 гишүүн маань ийм хууль санаачилсан, хууль санаачлах эрхийнхээ хүрээнд парламентынхаа тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр санаачилга гаргаж байгаа нь зүйн хэрэг байх гэж бодож байна. Надад 5 асуулт байна. Хуулийн төсөлтэй бид яах вэ 11 сард танилцсан. Одоо яах вэ зарим зүйлээ сэргээж харж байна л даа. Тэгэхлээр ингэж ойлгож байгаа зөв үү? Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын дарга болсон бол намаасаа бүрэн татгалзана гэж. Тэгэхлээр одоо намынхаа бүтцийн байгууллагуудын үйл ажиллагаанд гишүүнчлэлтэй байгаа шүү дээ. Энэнээсээ бүрэн татгалзаад, энэ үйл ажиллагаанд оролцохгүй гэдэг ийм жишээ нь зохицуулалт дагаад явна гэж ойлгож байгаа зөв үү гэж байгаа юм 1 дүгээр асуулт?

2 дугаар асуулт бид яах вэ энэ чиглэлээр судалж үзлээ л дээ, судалж ч байсан. Яг одоо энэ спикер буюу парламентын дарга нь намынхаа гишүүнчлэлээс татгалздаг жишигтэй улс нэг л байгаа юм Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс. Тэр Их Британийн жишээ нь парламентын доод танхимыг буюу жишээ нь нийтийн танхим гэж нэрлэдэг common house гэж нэрлэдэг. Энэ спикер татгалздаг юм байна. Яагаад гэдэг энэ түүхэн шалтгааныг судалсан уу? Энэ өөрөө 2, 3 шалтгаантай юм. Английн парламент чинь 1265 онд байгуулагдаад, орчин цагийн парламентын үндэс нь 1707 онд тавигдсан. Тэгээд цаанаа шалтгаантай, 3 шалтгаантай юм. Тэрийг сайн судалсан уу, энэ манайтай адилтаж болохоор зүйл байна уу гэдэг зүйл? 2 дахь асуулт байна.

3 дахь асуулт дийлэнх парламентын засаглалтай улсууд спикер бол парламентын дарга намаасаа татгалздаггүй. Тодорхой түвшинд намын үйл ажиллагаанаас түдгэлздэг улсууд байна. Энэ Канад, Энэтхэг байна, Австрали байх шиг байна. Тэгэхээр зэрэг яагаад эдгээр улсууд энэ парламентын даргыг намаас нь татгалзуулдаггүй, түдгэлзүүлдэггүй вэ гэдэг энэ шалтгааныг судалсан уу? Энийг та бүхэн нарийн мэдсэн байх гэж бодож байна.

Дараагийн асуулт хууль тогтоох үйл явцад хэрхэн нөлөөлөх вэ гэдэг ийм асуулт байгаа юм. Энэ парламент бол хамгийн гол нь хууль бидэнд чинь батлах ёстой шүү дээ, хэлэлцэж батлах ёстой. Тэгэхлээр энэ судалгаанаас харахаар зэрэг энэ бол хууль тогтоох үйл явцад бол сөргөөр нөлөөлдөг юм гэсэн ийм судалгааны

үр дүнгүүд гарсан байгаа юм. Удаашруулдаг, өөрөөр хэлбэл хэлэлцдэг парламент болчихдог учраас их удааширдаг гэж. Тэгэхээр өнөөдөр бид чинь маш шуурхай хууль гаргаад, бодлого гаргаад ингээд явах ёстой гэдэг ийм зүйлийг ярьж байгаа мөртөө энэнийхээ эсрэг ийм нөхцөл байдал үүсчих биш биз дээ гэсэн нэг ийм асуулт байна.

Дагалдаад дараагийн асуулт. Жишгээр бол хэрвээ жишээ нь парламентын дарга намаасаа татгалзвал дараагийн сонгуульд орохдоо бие даасан байдлаар ороод, тухайн тойрогт нь өрсөлдөгчгүйгээр сонгууль явагддаг ийм жишиг тогтчихсон байгаа юм. Тэгэхлээр энэ жишиг манай улс төрийн соёлд энийг дагаад тогтох уу, энийг та бүхэн яаж судалсан бэ гэдэг ийм асуулт байна? Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Парламентын судалгаа, түүх хоёрхон юмыг л илэрхийлж байгаа юм. Ямар парламент байгаагаас шалтгаалаад парламентын спикер төвийг сахих буюу төв ч байр сууриас асуудалд хандах ёстой. Энэ төвийг сахих гэдэг зарчмаа хэрэгжүүлэхийн тулд улс төрийн намын улс төрөөс ангид бие даасан байх ёстой гэдэг л зарчим тавьж байгаа. Энэ зарчмаа хэрэгжүүлэхийн тулд, хангахын тулд 2 арга хэрэглэж байгаа. Хатуу буюу аядуу 2 зохицуулалт. Хатуу зохицуулалт хэрэглэж байгаа нь Англи, Япон 2 намаас нь бүрэн түдгэлзүүлдэг. Намаасаа бүрэн түдгэлздэг учраас тэр намын дотоод улс төр болон намын улс төрөөс хамаагүй бие даасан байж чаддаг гэж үздэг. Ийм болох болсон маш олон түүхийн үйл явцууд байгаа юм.

Аядуу зохицуулалттай улс орнууд ер нь нийтлэг. Герман байна, Канад байна гээд бидний парламентыг нь дагаж, дагах гэж оролдож байгаа маш олон тогтолцоонууд байна. Шинэ Зеланд, Австралиас авхуулаад энэ аядуу зохицуулалттай улс орон. Аядуу зохицуулалттай улс орнууд парламентын спикерийг намаасаа түдгэлзүүлэхгүй, намын харьяалалтай байхыг нь зөвшөөрчхөж байгаа юм. Гэхдээ намын харьяалал нь ёс төдий. Харин нарийвчилсан зохицуулалтаараа 4 юмыг хатуу хязгаарлаж байгаа. 1 дүгээрт нь, парламентын намын бүлэгт харьяалагдахыг нь хорьчихож байгаа юм шууд. Сонгогдсон намынхаа бүлэгт орохгүй шүү гэдэг зарчим хатуу тавьчихаж байгаа юм.

2-т нь сонгогдсон намынхаа дотоод улс төрд өрсөлдөхгүй шүү гэдэг зарчмаа хатуу тавьчихаж байгаа юм.

3-д нь дахиад сонирхлын зөрчил үүсгэхгүйн тулд парламентын спикер зөвхөн парламентыг төлөөлөх бөгөөд улс төрийн сонгуульд нэр дэвшиж байгаа ямар нэгэн намын нэр дэвшигчийг дэмжиж, парламентаас гадуур үйл ажиллагаа явуулахгүй шүү гэж байгаа юм. Үг хэлэхгүй шүү, хэвлэл мэдээллийн хэрэгслээр харьцах харилцааг нь хязгаарлаж байгаа юм.

Дээр нь дахиад 4-д нь дахиад нэг зохицуулалт тавьж байгаа нь юу вэ гэхээр ганцхан тохиолдолд гэж байгаа юм. Олонх, цөөнхийн маргаан гарах, магадгүй нэг хүнээр зөрөх юм уу, 2 хүнээр зөрөөд олонх, цөөнх аль нь олонх вэ гэдэг эргэлзээтэй маргаан гарвал зөвхөн энэ маргааныг хагалах зорилгоор бүлгийнхээ хуралдаанд оролцох эрхийг нь нээж өгч байгаа юм. Нөгөө олонх сонгуулийн үр дүнгээр сонгогдсон олонхын статус өөрчлөгдөх гээд байгаа зөвхөн энэ маргаанд. Тэрнээс бусдаар бол тэгээд ер нь бүлгийн улс төр гэдэг ойлголтод спикер оролцохгүй. Олонх ч байна уу, цөөнх ч байна уу бүлгүүдэд тэгш эрхтэйгээр, тэнцвэртэйгээр хандах

ёстой гэдэг энэ зарчмаа барина л гэдэг юм ярьж байгаа. Тэгээд би өргөн барихдаа бид намаас түдгэлзэнэ гэдэг байдлаар өргөн барьсан. Хэлэлцүүлгийн явцад Монгол Улсад аль нь тохирох вэ гэдгээ бид ярилцаж болно. Энэ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн 1 минут тодруулга.

С.Зулпхар: Тэмүүжин гишүүнээ би 2 дахь асуултаа ахиж тодруулж асуух гээд. Энэ ихэнх улсууд чинь сонгоогүй байгаад байна л даа. Ийм одоо жишээ нь жишгийг. Яагаад гэдгийг та бүхэн судалсан уу? Ер нь бид ч заавал юмыг харьцуулж жишиж байж асуудал руу хандах ёстой шүү дээ. Та бүхэн нарийн судалдаг. Та өөрөө энэ чиглэлийн хүлээн зөвшөөрөгдсөн судлаачдын нэг учраас энэ дээр та бүхэн яг ямар үр дүн гаргасан бэ гэдэг?

Би 3 дахь, 4 дэх асуултынхаа хариултыг аваагүй байна. Хэрвээ ийм байвал тэр чинь хүлээн зөвшөөрөгдсөн спикер чинь улс төрч болчихлоо шүү дээ. Дараагийн сонгуульд жишгээр бол ямар ч өрсөлдөгчгүйгээр тойргоос шууд гардаг. Гэхдээ тэр нь Сонгуулийн хуулиар биш улс төрийн соёлоор зохицуулагдсан байдаг. Энэ дээр та бүхэн судалж үзсэн үү гэдэг ийм асуулт байна.

3 дахь зүйлийг нь бас асуумаар байна л даа. Энэ спикер аль намаас болоод байгаагаас болоод байгаа юм уу, эсхүл бид ажлаа хийж хуралдаа ирэхгүй байгаагаас болоод байгаа юм уу энэ парламентын чинь үйл ажиллагаа?

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: 4 дэх асуулт, 2 дахь болон 4 дэх асуултыг хариулъя. Түрүүн хууль тогтоох үйл ажиллагаанд яаж нөлөөлдөг вэ гэж. Хууль тогтоох үйл ажиллагаа удааширдаг гэдэг үг харьцангуй ойлголт. Энэ төвийг сахисан спикер байгаа нь парламентын хэлэлцүүлгийг нягт хийх, цөөнх үзэл бодол юм уу, үгээ хэлэх боломжийг нэмэгдүүлдэг учраас түүнийг нь удааширдаг гэж харж тайлбарлах өнцөг байдаг гэдэг үг байдаг юм байна лээ. Тэр дундаа олонх нь парламентыг өөрийнхөө аясаар хөдөлгөөд, асуудлаа хурдан шуурхай шийдвэрлэнэ гэдэг ийм амбицтай байгаа үед цөөнхийгөө үл тоох хандлага гардгийг нь харин энэ зарчим өөрөө зогсоож өгдөг гэдэг агуулга байгаа. Та бүхэн одоо анзаарч байгаа бол саяын сонгуулиас хойш бид ямар хурд.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут.

Х.Тэмүүжин: Сая өнгөрсөн 2 жилийн хугацаанд ЗГ-ын өргөн барьсан хуулийг яаралтайгаар гээд бараг гишүүд А гэж ангайж амжихгүй байхад алх цохиод хуулиуд батлагдлаа шүү дээ. Ийм парламент байж болохгүй шүү дээ харин яг эсрэгээрээ.

4 дэх асуулт бол үнэхээр улс төрийн соёл шаарддаг юм байна лээ. Намаасаа түдгэлздэг спикертэй холбоотой асуудал дээр дараагийн энэ өөрөө намын дотоод улс төрд орохгүй учраас ямар нэгэн бүлэг, фракцад харьяалагдахгүй, нөгөө гадагшаа хийх улс төр нь сулардаг учраас улс төрийн соёлоороо тойрог юм уу, эсхүл жагсаалт дээр спикерээ ямар нэгэн байдлаар багтаах гэдэг улс төрийн намуудын өөрийнх нь дотроо хүлээн зөвшөөрөх, үнэхээр спикер шиг байсан спикерийг дараагийн УИХ-д оруулна гэдэг парламентын өөрийнх нь дархлаа болон парламентат ёсны нэг үнэ цэн гэж үздэг юм байна лээ.

Ц.Сандаг-Очир: Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая. Хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье, их сонирхолтой асуудал, олон талаас нь харах ёстой. Монголын улс төрийн хөрсөнд соёолдог сорт байна уу, соёолдоггүй сорт байна уу гэдэг асуудал байгаа юм өөрөө их бодох ёстой асуудал энэ. Дам дамаа улс төрийн намын хатуу гишүүнчлэлтэй улс оронд энэ ер нь хэр зохицдог заалт юм бол гэж нэг.

Аливаа албан тушаалтны эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг хуулиар зохицуулдаг. Одоо хууль санаачлагчийн яриад байгаа асуудал яг нарийндаа тэр олон намын төлөөллийн жигд хангалт, мэтгэлцээний байх энэ нөхцөл энэ тэр магадгүй тэр эрх хэмжээ талдаа биежиж сууж байж хэрэгжилт нь илүүтэй гарах болов уу. Би тэр талаас нь хараад байгаа юм. Парламентын засаглалтай улс орнууд дотор яг энийг аваад хэрэглэчихсэн нь тун цөөхөн юм билээ. Хэрвээ үүнийг аваад хэрэглэвэл энэ даргынхаа цаашдын улс төрийн гэдэг юм уу, сонголтынх нь асуудлыг хуулиар нээж өгдөг, тийм тохиолдлууд байна гээд үүнийг ярих асуудлууд нэлээн байгаа юм билээ. Тийм учраас би хэлэлцэхийг нь дэмжээд, ажлын хэсэг гараад, хэлэлцүүлэгт бэлтгээд, тал бүрийнхээ судалгаа юмнууд дээр тулгуурлаад боловсронгуй болгоод, ингээд яриад явах нь нэг их ч буруугүй байх.

Харин би ганц олзуурхсан юм нь Улсын Их Хурлын даргыг сонгох асуудал дээр гишүүд санал бодлоо илэрхийлэх барих энэ юм нь өнөөдрийн хуулиар хаалттай байгаа. Энийг нээх ёстой, үнэхээрийн ийм зарчим байх ёстой гэдэг ийм санал байгаа юм. Тийм учраас би авах заалт байна, эргэж харж судалгаа тооцоо хийх ч зүйл байна. Гэхдээ энэнд явахын тулд хэдүүлээ хэлэлцэхийг нь дэмжээд, ажлын хэсгээ тал бүрээсээ төлөөлөл оролцуулж байгуулаад, тэгээд нэлээн сайн судалж үзээд боловсронгуй болгоод явах ёстой болов уу л гэсэн ийм байр суурьтай байгаа. Түрүүн Гантөмөр дарга та байр сууриа илэрхийлэхгүй юу гээд байна лээ. Би яг ингэж илэрхийлмээр байна.

Ц.Сандаг-Очир: Үг хэллээ. Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Өөр дуу хоолойг нээнэ гээд тэгж байна. Энэ хуулиар оруулж байгаа өөрчлөлтөөр өөр дуу хоолой бүрэн нээгдэхгүй юм байна гэж харагдаж байна. Ардын нам, АН-ын бүлгүүд, төлөөллүүд хоорондоо уулзаад, ингээд парламент болчихлоо энэ хуулийг батална гэж байна. Бусад намууд нь оролцсон юм уу, ярилцсан юм уу, ямар нэг байдлаар байдлаар санал асуусан юм уу, байхгүй. Тэгээд 5 намын дуу хоолой болно гэдэг.

Дээрээс нь энэ хууль дээр чинь Бямбацогт байна уу, хэн байна уу өнөөдөр спикер томилогдох гэж байгаа гэдэг утгаараа энэ мөчид зориулж оруулж ирж байна. Дахиж нэмж ажиллаад, Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр би олон удаа хэлж байсан. Энэ 5 нам чинь хоорондоо яриад, энэ Сонгуулийн хууль, Дэгийн тухай хууль, бусад энэ зүйлүүдээ нэг эмх цэгцтэй болгоод тавьчихаж болохгүй юм уу гэж? Цэндийн Нямдорж гуайг Их Хурлын дарга байхад та намын гишүүнчлэлээсээ татгалзаж болдоггүй юм уу гэж би өөрөө нэгдсэн чуулган дээр асууж байсан. Үгүй ээ татгалзлаа гээд яах вэ дээ би намаараа л үлдэнэ шүү дээ гээд хариулж л байсан. Хэрвээ үнэхээр парламент сонгодог парламент руугаа явуульъя гээд явж байгаа бол Ерөнхий сайд нь Их Хурлаа тараадаг болгож болохгүй юу?

Дээрээс нь бүлэгт харьяалагдаагүй гишүүд гээд байгаад байдаг, 10 гэдэг тоо тавьчихсан. Ард түмний төлөөллийн нэг хэсгүүд нь ямар ч бүлгийн зарим эрхийг нь ч эдэлж чаддаггүй. Тодорхой асуудлууд дээр завсарлага авах эрх байхгүй. Тэгээд Их Хурлын дарга нь нам бус байвал дэд дарга нараа бас нам бус болгох юм уу? Бүлгүүдээс гарч ирж байгаа дэд дарга нараа нам бус болговол яасан юм бэ бүгдийг нь хамтад нь. Хамгийн гол нь үргэлжлүүлээд хэрвээ ингээд парламентын ардчилал, парламентын асуудал хүндрээд байна гэж үзвэл цаашлаад энэ парламент чинь Ерөнхийлөгчөө сонгодог болгох ёстой юм уу, үгүй юм уу? Улс төрийн намуудын парламентад суудал бүхий намуудын зохицол, хоорондоо зөвлөлдөх, ойлголцох тэр асуудал дээр анхаарал тавьсан юм огт алга байна шүү дээ.

Их Хурлын дарга нь нам бус байна гэдэг дээр би нэг их эсэргүүцээд байх юм байхгүй. Гэхдээ зөвхөн нэг тохиолдолд зориулж ийм явцуу улс төр хиймээргүй байна. Энийгээ Их Хурлын дарга захирамж гаргадаг юм уу, яадаг юм тэгээд энэ 5 намын удирдлагуудаас нь, төлөөллүүдээс нь оролцуулаад, парламентад суудал бүхий намуудад байдаг тэр ойлголцлуудыг нь хийгээд, ингээд цаашаа явах ёстой санагдаж байна. Тэгээд хэлэлцэх эсэх асуудал дээр нь дэмжих ёстой байх.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Өнөөдрийн энэ хуулийн төсөл Үндсэн хуулийнхаа араг яс дотор л бид хуулийн төслөө өргөн барьж байгаа. Үндсэн хууль өөрчлөх тийм санал санаачилга одоогоор гаргаагүй. Монгол Улсын Үндсэн хууль дээр маш тодорхой заасан байгаа. Улсын Их Хурлын даргыг гишүүд дотроосоо илээр санал хурааж, нэр дэвшүүлж сонгоно. Дэд дарга нарыг нам, эвслийн бүлэг тус бүрээс сонгоно гээд маш тодорхой заачихсан. Аль нь намчирхдаг, аль нь намчирхдаггүй тухай Үндсэн хууль бол энэ албан тушаал дээр хил заагийг нь маш тодорхой гаргаж өгсөн. УИХ бол ..., хүссэн, хүсээгүй 126 гишүүнээс бүрдэж байгаа боловч нэр дэвшиж байгаа үйл явцаасаа шалтгаалаад намаас хамааралтай. Тийм учраас намын оролцох орон зай бол тэнцвэрийг хангахын тулд дэд дарга нарт байгаа шүү. Улсын Их Хурлын даргын хувьд энд нам оролцох шаардлага байхгүй шүү гэдэг агуулгатай үг, үсэг маш тодорхой бичигдсэн юм байна лээ.

Тэгэхээр бид олон намын тогтолцоотой байдаг учраас төвийг сахисан намуудын дуу хоолойг жигд хамгаалахад зориулсан энэ спикертэй байх гэдэг харин Батбаатар гишүүнээ нөгөө цөөнх дуу хоолойгоо гаргадаг байх гэдгийн чинь хамгийн суурь зарчим. Энэ суурь зарчим руугаа бид алхъя л гэж байгаа юм ерөөсөө гол агуулга нь. Хэлэлцэх эсэхээ шийдчихээд, ажлын хэсэг байгуулаад, тэгээд ярилцаад явах бол намуудын эрх хэмжээний л асуудал. Гэхдээ бид нэг юмыг хатуу бодох ёстой. Монгол Улс бол парламентын засаглал бүхий улс. Түрүүн хэд хэдэн удаа гарлаа. Парламентын засаглал бүхий улс орнуудад ингээд судалгаа хийхэд тэр улс орнуудын чинь бараг 80 хувьд нь шүү соёлоороо болон хуулиар нарийвчлан зохицуулсан байдлаараа парламентынхаа спикерт ерөөсөө л төвийг сахих. Төвийг сахих баталгаа нь сонгогдож гарсан намынхаа улс төрөөс ангид байх гэдэг энэ 2 зарчмыг л барьж байгаа.

Та бүхэн энэ 11.4 дээр байгаа өгүүлбэрийг би дахиад уншаад өгье. Улсын Их Хурлын дарга нь намуудын улс төрөөс ангид, бие даасан, төвийг сахисан байр сууриас бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Улсын Их Хурлын дарга Олон улсын парламент холбоо /ОУПХ/ хоорондын тохиролцсон албан тушаалаас өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно. Энэ бүүр нийтлэг зарчим юм билээ парламентуудын.

Бид энэ зарчмыг парламентынхаа хууль тогтоомжид хийж аваад, спикерээ энэ түвшинд аваачвал энэ түүх болно. Дараагийн 30 жил энэ үеийн парламент сонирхлын зөрчилгүй, намчирхаагүй, улс төрийн хязгаарлагдмал, явцуу ашиг сонирхолд хөтлөгддөггүй парламентын спикертэй болсныхоо үр дүнд цөөнх, олонх нь жигд дуу хоолойтой байдаг, мэтгэлцдэг бодлогоо ярьж.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Батбаатар гишүүн 1 минут.

Б.Батбаатар: Энэ хуулийн төсөл дээр бичигдсэн зүйлээс нь биш, бичигдээгүй хэсгүүдээс нь илүү асуусан шүү дээ. Яах вэ төслийнхөө хүрээнд хариулна гээд хариулаад явчхаж болно, болно, шаардлагагүй өөр юм ярихгүй гээд. Гэхдээ нэг асуудал энэ ажлын хэсэг нь байгуулагдахад, хэрвээ ажлын хэсгийг хэн байгуулдаг билээ Их Хурлын дарга, яах вэ оруулбал ажлын хэсэгт нь орё. Тэгээд Ерөнхий сайд парламент тараадаг заалтыг энэ хууль дээр чинь нэмнэ, санал оруулна. Үгүй ээ харин тэгээд цаашаагаа явна л даа. Үгүй ээ үгүй, тэгээд хэдүүлээ үнэхээр парламентын ардчиллыг, парламентынхаа асуудлыг шийдье гээд байгаа бол хүссэн, хүсээгүй Үндсэн хууль руугаа орно шүү дээ. Гантөмөрөө, Цэндийн Нямдорж гуайг Их Хурлын дарга байхад намаасаа татгалзаач гээд.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Миний зүгээс нэг зүйл асууя. Тэмүүжин гишүүнээс хууль санаачлагчаас асууя. Энэ 2 дугаар зүйл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай гэж байгаа юм. Энэ заалт нь болохоор нөгөө Хянан шалгах түр хороог чуулганы хугацаанд 2-оос дээшгүй байгуулах энэ асуудал байгаа. Энийг хүчингүй болгоод дэмжчихвэл чуулганы хугацаанд ер нь хэчнээн ч хамаагүй хянан шалгах түр хороо байгуулагдах тэр бололцоо боломжтой болох гэж байна. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийн шатанд гэдэг юм уу бас нэг тоо тавьсан нь дээр байх. Баахан хянан шалгах түр хороонууд гарч ирээд л. Тийм, 2 бол магадгүй зүгээр, бас тэгэхдээ огт тоогүй байж болохгүй байх гэж бодож байна. Энийг хэлэлцүүлгийн шатанд хэдүүлээ ярилцаж байгаад нэг тоо байхгүй бол тэгээд эцэстээ нөгөө Хянан шалгах түр хорооны үндсэн зорилго чиглэл алдагдаад, ач холбогдол буураад, дагасан төсөв санхүүгийн асуудал хаанаас гарах билээ эд нар гээд асуудлууд яригдах юм шиг байна. Тийм учраас энэ дээр гишүүд анхаарлаа хандуулж, энэ заалтыг ерөөсөө ярихгүй байгаа юм. Тийм учраас энэ заалт дээр энэ нэгхэн өгүүлбэрээр энэ том асуудал орж ирж байгаа гэдгийг анхаарна биз дээ гэдгийг хэлчихье.

Гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Батбаатар гишүүн, Гантөмөр гишүүнээр тасаллаа. Ирцийн дараалал, орсонгүй ээ? Номтойбаяр гишүүн ирцэд орчихсон л байна даа. Таных хаана байна вэ? Номтойбаяр гишүүнийг оруулаарай. Ирцийн дарааллаар Гантөмөр гишүүн үгээ хэлье.

Л.Гантөмөр: Монголын улс төрд Монголчуудын амьдрал яг юу болоод байгааг би энэ Батжаргал дарга энэ тэрийн хэлж байгаагаас харахад та нар ер нь юмаа ойлгохгүй байгаад байх шиг байна. Тийм, энэ бол асар том хямрал эхэлж байна. Ерөөсөө энэ Их Хурал дээр яг ард түмнийхээ дуу хоолойг сонсдог байхын тулд парламентын дарга чинь дархлаатай болохгүй бол бие даахгүй бол болохооргүй байна. Сөрөг хүчин завсарлага авахаар нэг цагийн завсарлага өгдөг парламент ер нь дэлхий дээр хаана байдаг юм. Энэ бол улс төржиж байгаагийн л

хэлбэр байхгүй юу. Юм чинь болохгүй байна, гарц гаргалгаа гаргаач гэхлээр зөрөөд улс төржөөд байдаг.

Тэгэхдээ та хэд яах вэ ингээд нэг хэлэлцсэн болоод өнгөрөөд, тэгээд цаашаагаа хулхидъя гэж байгаа юм байна л даа. Тэгвэл араа өөрснөө даана шүү, тоглоом биш шүү. Энэ ард түмнээс сонгогдсон хүмүүс чинь үзэл бодлоо хэлмээр байна, үгээ хэлмээр байна. Мах өнөөдөр 40 мянга хүрснийг зохицуул гээд ингээд суугаад байгаа шүү дээ. Тэгэхээр би Бямбацогт дээр зүгээр өөрт нь акцент өгмөөр байгаа юм. Уг нь юм бариад авбал хийдэг хүн. Энэ хуулийг гаргана шүү.

Одоо би ингээд сонсоод байхад, зарим гишүүдийн ярьж байгааг хараад байхад нэг тоглоом шоглоом болгоод, тэгээд цаашаагаа ингээд цайруулаад, Их Хурлын даргаа бид заавал олонхынхоо Бүлгийн хуралд суулгана барина гээд ингээд завааруулах юм байна. Тэгээд заваараад явбал харин арыг бол үнэхээр өөрснөө даана шүү. Одоо бол болохоо больчихоод байна шүү. Институтууд ялгарахаа больчихсон шүү. Их Хурал нь Их Хурал шиг байхаа больчихсон. Ерөнхийлөгч Ерөнхийлөгч шиг байхаа больчихсон. ЗГ ЗГ шиг байхаа больчихсон. Тийм учраас хэдүүлээ чаддагаараа эхлээд Их Хурлаа татаад авчихъя л гэж байхгүй юу. Ингээд цаашаагаа ажил төрлөө хийхгүй бол ард түмний амьдрал чинь балраад байна шүү дээ. Энэ юмны үнийн өсөлт гэдэг зүйл чинь ерөөсөө болохгүй байна шүү дээ. Хүмүүсийн олж байгаа орлого үнэндээ амьдралд нь хүрэхгүй байна шүү дээ. Тэгээд хэдүүлээ энийг мэдсээр байж мэдэн будилаад суугаад байж болохгүй байх.

Тэгээд Ардын намынхан минь жоохон сэтгэл гаргаач л гэж хүсмээр байгаа юм. Энэ хуулийг Сандаг-Очир дарга бол оройлоод ТББХ-ны дарга би энэ хуулийг батална гээд зүтгээд байхад эсэргүүцээд байдаг хүн ховор шүү дээ. Тэгэхээр улс төрийн бүлгийн ямар нэгэн эрх ашиг биш, Монголын парламентын эрх ашгийг бодож 7-гоос 10 хоногийн дотор энэ хууль батлагдах ёстой шүү гэдгийг би найзууддаа хэлмээр байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Ерөөсөө маш товчхоноор хэлэхэд энэ нийгэмд шийдвэр гаргаж байгаа үйл явцыг харахад иргэдийн сэтгэл хөдлөлийг залуурдах чиглүүлэх, түүнд тодорхой ашиг сонирхолтой үйлчлэл хийх, энгийнээр хэлбэл манипуляц хийх, тархи угаа угаах ийм процесс маш их болж байгаа. Ялангуяа сонгуулийн үед болдог байсан үйл явдал нь өдөр тутам болдог болчихсон. Тэгэхээр яг бид ингээд цэвэр оюун санаагаар, уураг тархиар, саруул ухаанаар асуудлыг шийдэхээс илүүтэйгээр салхинд хөөгдөж байгаа хамхуул шиг PR-ын шийдэл гаргадаг болчихоод байгаа юм. Энэ нь бол Төрийн ордонд асар хүчтэй ороод ирчихсэн, тэр цунамигийн гол голомт нь Төрийн ордноос ашиг сонирхолтой хүмүүсээс гардаг болчихоод байгаа юм. Энийг таслан зогсоох зүйл юу юм бэ гэхлээрээ хувь хүний сэтгэл хөдлөл, нөгөө талд нь институт 2-ыг бид ингэж ялгаж салгах зайлшгүй шаардлагатай болчихоод байгаа юм.

Тэгэхгүй болохлоор энэ сайн хүн юм, эсхүл энэ муу хүн юм гэсээр байгаад энэ хандлагаасаа болоод цаана нь байгаа институцийн мөн чанараа бид гээчхээд байдаг болчихсон. Энэ үүднээс парламентын засаглалын ач холбогдлыг үгүй хийх, бууруулах энэ зүйлүүд байгаа. Манай улсын парламентын хамгийн өндөр ёс зүйтэй хүн хүртэл бие хамгаалах урлагийн мэх хийх түвшинд хүрчихсэн байгаад байгаа юм. Яагаад гэхлээр УИХ-ыг хэн ч хүндлэхгүй болчихсон. Засаг нь ч хүндлэхгүй, хот нь ч хүндлэхгүй. Энд хүндлэл гэдгийн цаана хариуцлага, хяналт тэнцэл буюу check and

balance баланс явж байх ёстой байхгүй юу. Хууль санаачлах, санаачилсан хуулиа хэрэгжүүлэхэд хяналт тавих ёстой парламент нь сайд нараа дуудаад ирдэггүй, ЗГ-таа шаардлага тавиад тэр нь ор нэр мөр. Ингээд хотод тодорхой хэмжээгээр шаардлага тавиад энэ үндэслэлүүдээ тайлбарла гэхээр пээдийгээд байдаг ийм л болчихсон.

Энэ үүднээс цаашаагаа нөгөө цэр нь цээжиндээ бөгс нь бөөрөндөө гэдэг шиг зарчмаа дагах ёстой, хуулиа дагах ёстой гэсэн зүйл явж байгаа юм. Энд одоо улс төрчид юм уу, ялангуяа энэ эрх баригчид эмзэглэх хэрэггүй. Энэ цаашдаа Монголд хэрэгтэй зүйл болно. Парламентын засаглалыг, парламент ёсыг чадавхжуулахад хэрэгтэй зүйл болно. Зүгээр хуулийн төсөл дээр байгаа тодорхой зүйлүүд хэлэлцүүлгийн явцад бол наанатай цаанатай яригдах байх. Жишээлбэл Их Хурлын даргыг сонгох сонголтын тооны асуудал ч гэдэг юм уу, саналын тооны асуудал ч гэдэг юм уу энэ дээр хүмүүс олон ургалч үзлүүд гарах байх гэж бодож байгаа юм. Тэгэхээр ер нь одоо бид ялангуяа энэ парламентад байгаа хүмүүс энэ төрийн ордноосоо энэ манлайллыг эхлүүлэх ёстой. Бүх юман дээр баримтын шалгалт буюу fact checking хийдэг байх ёстой. Улс төрчид байр сууриа илэрхийлэхдээ, мэдээлэл хийхдээ бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй, ёс зүйтэй, хариуцлагатай, бодитой, баримттай зүйлийг хүйтэн тархи, хүйтэн логикоор ярьдаг байх ёстой.

Тэгэхгүй бол ерөнхийдөө ингээд нэг өдөр улсаараа хэн нэгнийг ардын баатар болгоод, нөгөө өдөр нь улсаараа түүнийг төрийн дайсан болгодог ийм л болчихсон. Энэ сэтгэл хөдлөлөөр удирдуулсан, эмоцид түшиглэсэн улс төр гэдэг Монголын сайн сайхныг хорлож байгаа юм. Тийм учраас бүгдээрээ энэ хуулийг үзэл санааных нь хувьд дэмжээсэй гэж бодож байна. Энэ зөвхөн өнөөдөр эрх баригч намыг чадах гээд байгаа сөрөг хүчний үйлдэл огт биш бөгөөд урт хугацаандаа Монголын парламент ёсны төлөвшилд асар хэрэгтэй эмчилгээ гэж харж энэ үнэт зүйлийг дэмжээсэй гэж бодож байна. Нөгөө талаасаа завсар дунд нь байгаа засах шаардлагатай санаа оноонууд дээр бүгдээрээ нээлттэй хэлэлцүүлэг явуулъя гэдгийг та бүхэнд хэлмээр байна.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Төр цэгцрэх, УИХ цэгцрэх энэ ажил Улсын Их Хурлын даргыг сонгох үйл явцтай зэрэгцээд хийгдээд, Улсын Их Хурлын дарга нам бус байх, аливаа нэг байдлаар улс төржихгүй байх гэдгээс эхэлж байна л даа. Энэ дээр дэмжинэ. Гэхдээ бид аливаа асуудлыг цогцоор нь, бүтнээр нь хардаг баймаар байгаа юм. УИХ гишүүн ард түмний элч төлөөлөгч, нийт иргэн, улсын ашиг сонирхол, эрх ашгийг эрхэмлэх ёстой. Тэгээд энэ дээр одоо хэдүүлээ бүх өнөөдөр ард түмний төрд итгэх итгэл маш их унаж байна. Нийгэм шударга ёсыг маш их хүсэмжилж байна. Тийм болохоор үнэхээр энэ Их Хурлынхаа төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага болсон Улсын Их Хурлынхаа нэр хүндийг сэргээх, ингэхийн тулд Улсын Их Хурлын даргаасаа эхлээд Улсын Их Хурлын гишүүд нь, УИХ нь өөрчлөлтийг өөрсдөөсөө, төрөө цэгцлэх ажлыг төрийн эрх барих дээд байгууллагаа дээрээсээ эхлээд шийдэх тал дээр тууштай, манлайлж зүтгэж, санаачилж ажиллана гэж би бодож байгаа.

Тэгээд энэ ажлын эхлэлийг үр дүнтэй хийцгээе. Араас нь залгаасыг нь гишүүд маань өөрсдөө хариуцлагатай байх, улс төржихдөө улс орныхоо эрх ашгийг боддог байх, аливаа нэг нам, бүлэглэлийн хувийн эрх ашгийг урьд нь тавьдаггүй байх энэ талд анхаарах ёстой байх. Сая Батжаргал дарга хэллээ. Улсын Их Хурлын даргыг

сонгох хэлэлцүүлэггүй явдаг, шууд хэлэлцүүлэггүйгээр шууд сонгоно гэсэн хуулийн заалт байж байгаа. Энэ заалт хэзээ, яагаад орчихсон юм, хэнд зориулсан юм. Иймэрхүү юмнуудыг цэгцлэх ёстой. Улсын Их Хурлын дарга бол Улсын Их Хурлын гишүүддээ хүлээн зөвшөөрөгдсөн, ард түмэндээ хүлээн зөвшөөрөгдсөн хүн байх ёстой. Хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийг нь ард түмэн, УИХ дээр хэлэлцэж байж, асуулт асууж байж, санал бодлыг нь сонсож байж, гишүүд санал бодлоо хэлж байж тэр чинь ямар хүн бэ гэдэг нь харагдана. Гэтэл ийм хэлэлцүүлэггүй явдаг ийм хуультай болчихсон. Яагаад ингээд ийм хууль хийчихсэн юм. Энийгээ бид засах ёстой цаашдаа.

Мөн одоо энэ орж ирж байгаа асуудал, энэ хуулийг хүнд зориулж битгий хийгээсэй, хийвэл төгс хийе. Зөвхөн эрхийг нь хязгаарлаад хаячихдаг, үүрэг нь байхгүй, хариуцлага байхгүй тийм биш, эрх, үүрэг, хариуцлага хамтдаа байх ёстой. Улс төржихгүй, намаас түдгэлзээд тодорхой хэмжээнд төвч байр сууриас асуудалд хандах ёстой. Эргээд энэ хүн чинь дараагийн ажил, амьдрал байж байгаа. Түүнийх нь баталгаа юу байх юм энэ бүгдийг цогцоор нь хийх ёстой. Сая энэ хуулийн төслийг харахад 11 сарын 20-нд өргөн барьсан юм байна. 2025 оны 11 сарын 20-нд Манай Тэмүүжин гишүүн санаачлаад. Тийм болохоор одоо энэ хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжээд, цааш нь хэлэлцүүлэх явцдаа зөвхөн одоо юу гэдэг юм нэг талыг нь авч явдаг, талыг нь хаядаг, эсвэл хэн нэгэнд зориулдаг биш, үүнийг ер нь парламентын спикер цаашдаа мөнхөд ийм байх цогц болгож сайжруулах ёстой шүү. Тэгэхгүй нэг талыг нь авч явчхаад, талыг нь хаячхаад, ингээд нэг хүнд зориулчхаад ингээд ийм байдлаар явах ёсгүй байх. Тийм болохоор одоо хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байна. Цаашдаа илүү төгөлдөржүүлж, сайжруулах тал дээр хамтарч ажиллацгаая гэдгийг энд хэлье.

Ц.Сандаг-Очир: Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Миний цаг яваад байна шүү хүмүүсээ, би цагаа шинээр эхлүүлэх юм уу Гантөмөр даргаа, хажуугаар яриад. Өнгөрсөн хугацаанд АН ерөөсөө нэг л шаардлага тавьсан шүү дээ. Энэ Их Хурлыг удирдаад байгаа хүн нам бус байя, намчин биш байя л гэдэг шаардлага тавьсан. Тэрнээс АН зарчмын шаардлага тавьсан болохоос биш юу гэдэг юм, тийм албан тушаал, тийм сайдын суудал, ийм юм авъя гээгүй. Тэгээд өнөөдөр энэ бидний шаардлага биежих, хэрэгжих үндэс нь ерөөсөө энэ. Харин энэ зарчмын шаардлага тавиад нэг намын даргаар удирдуулахгүй гэсний төлөө манай эрх баригчид ээлжилж гарч ирээд л төрийн ажлыг гацаалаа, явуулахгүй байна, суух ёстой гээд л баахан ярьсан. Цаагуураа зөндөө юм боллоо шүү дээ бид харлаа. Ер нь төрийг хүчээр уураар, өс хонзонгоор бүр удирдахгүй. Өс хонзон энэ тэр чинь бид харж байна шүү дээ, Монголын ард түмэн харж байна, эхнэрийн урхи цаашаа л юм болж байна шүү дээ ер нь, бүгдээрээ л харж байна.

Гэтэл уг мөн чанартаа бид зарчмын шаардлага л тавиад байгаа юм. Намчин хүнээр битгий удирдуулаач, намчин хүн Их Хурлыг битгий даргалаач, намч хандлагаа битгий гаргаач л гэсэн ийм л шаардлага тавиад байгаа нь өнөөдөр бидний гишүүдийн санаачилсан энэхүү хуулийн төсөл байгаа юм. Энэ зөвхөн энэ удирдлагаас гадна бас нэг чухал зүйл энд хяналт шалгалтын түр хороог илүү байгуулж болох тухай байгаа юм. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө хүсэж байгаа асуудлаар өөрсдийнхөө шалгах шаардлагатай асуудлаар хороо байгуулна гэхээр давхацдаг, дараалал үүсдэг нэг ийм хачин юм болоод, дараа нь нөгөө хороо байгуулах гэж байгаа гишүүд нь хоорондоо

муудалцаад, манайх түрүүлж байгуулах ёстой, танайх ингэх гээд байна гээд ийм асуудал хүртэл гарч байсан. Энийг засъя гэж байгаа юм.

Тийм учраас цаашдаа Монгол төрийг хүчээр, өс хонзонгоор, намч хандлагаар удирдахгүй байхад чухал шаардлагатай энэхүү хуулийн төслийг дэмжиж өгнө үү хэмээн хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн. Энэ парламентын засаглалын, парламентын тогтолцооны давуу тал нь л бид ингээд тойрч суугаад асуудлаа ярьж байгаад байгаа юм. Тэгээд энэ парламентын засаглалтай байгаагийн энэ давуу талыг бид цаашдаа ч гэсэн хадгалаад явна. Аливаа жишээ нь асуудал, хуулийн төсөл орж ирэхэд тал талаас нь, тэгэхдээ мэргэшсэн rational сэтгэлгээнд суурилсан байдлаар бид хэлэлцэх ёстой. Энийгээ бид өнөөдөр яг хэлэлцэж байна. Өнөөдөр энд бид 32 гишүүн байхаас Байнгын хорооны 22 гишүүн сууж байна, бүх намын төлөөлөл, эвслийн төлөөлөл сууж байна шүү дээ ийм л байх ёстой цаашдаа.

Би зүгээр мэдээж хэрэг гишүүнийхээ санаачилсан төслийг бид энд хэлэлцээд, хэлэлцэх эсэхийг нь дэмжих эсэх нь бол бидний байж л болох гаргах шийдвэр. Бид тийм шийдвэр гаргаж болно, гаргах ч ёстой. Дараа нь хэлэлцэх явцдаа харин энэ хуулийг илүү бид нарийн судалж байж боловсронгуй тийм хууль гаргахын төлөө ажиллах ёстой. Энийг бид тал талаасаа ойлгож байгаа гэж бодож байна. Гэхдээ яах вэ бид бие биедээ одоо буруу тохоод яах вэ. Би эргэн тойронд учир мэдэх улсуудтай байна. Учир мэдэх улсууд юу гэж хэлж байна вэ гэхээр зэрэг та нарын парламентын жишээ нь дарга чинь намын гишүүн байна уу, гишүүн биш байна уу тэр их чухал биш гэж байгаа юм. Хамгийн гол нь танай парламент чинь ажилладаг байх ёстой гээд байгаа байхгүй юу. Бид ажилдаа ирэхгүй, хурлаа хийхгүй байгаа учраас тэрийг л шүүмжлээд байна өнөөдөртөө.

Гэхдээ бид бол парламент дотроо өнгөрсөн хугацааны туршлагаа хараад үнэхээрийн парламентын дарга намаас ангид байхгүй бол ямар нэгэн байдлаар энэ хууль тогтоох үйл явцад нөлөөлдөг юм байна гэдэг ийм зүйл яриад сууж байгаа нь бол байж болох л зүйл. Энийгээ яриад, бид хэлэлцэх нь бидний асуудал шүү гэж байгаа юм. Гэхдээ яах вэ би зүгээр түрүүн асуулт дотор чинь энэ тэгээд санал явж л байдаг, хариулт явж л байдаг юм чинь би асуултаараа зориуд асуугаад байгаа юм л даа. Яагаад бид ганцхан улс жишиг болгосон энэ парламентынх нь дарга нь намаасаа бүрэн түдгэлздэг энэ жишгийг авах гээд байгаа юм бэ гэдгийн үндэслэлийг та бүхэн сайн тайлбарлаач л гэж байгаа юм. Бүрэн тайлбарлаж байж, бид бүрэн хэлэлцэж байж энийг авах ёстой.

Гэтэл бусад улсууд нь энийг яагаад одоо сонгоогүй байгааг бас бүрэн тайлбарлах ёстой. Тэр чинь цаанаа шалтгаан байгаа шүү дээ. Шалтгаан байгааг нь угаасаа судлаад гаргаад ирчихсэн янз янзын эрдэм шинжилгээний өгүүлэл ч байна, судалгааны тайлангууд ч байна. Тэрийгээ үзэх ёстой. Ингээд ирэхээр зэрэг би энэ асуудлыг юу гэж ойлгож байна вэ гэхээр зэрэг бид Их Хурлын гишүүд хууль тогтоогчдын хувьд бол энийг хэлэлцэнэ, энэ бидний үүрэг, бидний эрх ч байх, чиг үүрэг. Нөгөөтээгүүр энэ дээр судлаачдын байр суурийг маш сайн сонсох ёстой. Төр эрх зүйн чиглэлээр, Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр, улс төрийн улс төр судлаачдын байр суурийг сайн сонсож байж бид энэ дээр шийдвэр гаргах ёстой шүү гэж байгаа юм. Энэ чиглэлээр мэдээжийн хэрэг ажлын хэсэг ажиллах байх. Би хувьдаа түрүүн Батбаатар гишүүн хэлж байна, ажлын хэсэг байгуулагдвал ажлын

хэсэгт орох ийм саналаа илэрхийлэх ийм бодолтой байна. Тэгж байж энэ дээр ажиллана гэсэн ийм бодолтой байна.

Тэрнээс гадна сая гишүүд маань хэлж байна. Бид зөвхөн энэ хуулийн хүрээнд гишүүнээс нь түдгэлзүүлэх асуудлыг ярих уу, цаашдаа хэрвээ түдгэлзлээ гэхэд, татгалзлаа гэхэд парламентын үйл явцыг парламентын спикер буюу дарга нь хэрхэн удирдаж, хэрхэн чиглүүлэхтэй холбоотой энэ асуудлыг нарийн тодорхойлж оруулах ёстой шүү гэж байна. Энийгээ бид ярих ёстой байх гэж байна. Бас л дараа нь жишээ нь нэг түүхий хууль хийчихлээ гээд араас нь явдаггүй баймаар байна гэж байгаа юм. Хамгийн ойрын жишээг та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Бид 2 хоногийн өмнө хэлэлцлээ. Аймаг, нийслэл, дүүрэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийг бид өөрчилснөөс болоод өнөөдөр асуудал үүсгэчихсэн сууж байгаа шүү дээ, Үндсэн хуулийн цэц /ҮХЦ/ дээр маргаан үүсээд, ҮХЦ бол нэг хуулийг зөрчөөгүй, нөгөө хууль нь бол асуудал үүсгэчихсэн гэж байгаа юм. Тэгэхлээр ийм хууль гаргахгүйн тулд нарийн судалж байж бид энэ асуудлыг ярих ёстой гэж бодож байна. Ингээд мэдээж хэрэг энэ асуудлыг хэлэлцэхийг бол дэмжиж байна. Гэхдээ нарийн хэлэлцэж байж, бүгдээрээ тал талаас нь няхуур ажиллаж байж энэ хуулийг бол одоо яах вэ гэдэг шийдвэр гаргах байх гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Батбаатар гишүүн үгээ хэлье.

Б.Батбаатар: Бид 126 гишүүнтэй парламент тангараг өргөөд Их Хурлын дарга сонгогдоод, тэрний дараа үг хэлж сануулж байсан зүйл, үгнүүд маань протокол дээр хэвээрээ үлдсэн байх. Намч байж болохгүй, намын генсек, Засгийн гал тогоо, Хэрэг эрхлэх газрын дарга байсан, хавсарч байж байсан парламент удирдахад намч байж болохгүй шүү гэдэг үгийг маш олон удаа би хэлж байсан. Ерөнхий нарийн бичгийн даргаа санал оруулаад ирж байх үед. Тэгэхээр энэ талдаа миний байр суурь нэг байгаад байгаа юм 20 жил өөрчлөгдөөгүй яваад л байгаа.

Харин энэ манай нөхдүүд баахан хэл ам тарьж, тарьж Даргын дэргэдэх зөвлөлд харин намуудын төлөөлөл ордог болчихсон. Уг нь 2 намын бүлгийн дарга, дэд дарга, тэр Байнгын хороодын дарга нар ороод л ингээд дуусчихдаг байсан. Тэгэхээр тэнд парламентын хэлэлцэх асуудлууд болон бусад асуудлууд дээр ингээд намуудын оролцоог нэмэгдүүлж өгсөнд талархдаг. Одоо энэ зүйлээ бас энэ хууль дэг юм өөрчлөхдөө нэмэлтүүдийг нь хийж өгөөч гэж хэлээд байгаа юм. Жишээлэхэд манай Иргэний Зориг ногоон нам бол Их Хурлын дэд даргатай болох шаардлага байхгүй бүлгүүд шиг, харин завсарлага авдаг эрхтэй баймаар байгаа байхгүй юу. Тодорхой асуудал дээр, санал зөрөлдөөнтэй байх үед. 118-ын бүлэг байх үед завсарлагын эрх байхгүй, дуу хоолой нь энийг давж чадахгүй маш хүнд байсан шүү дээ. Одоо ч гэсэн энэ хууль өргөн баригдаад, 4 сарын дараа анхныхаа хэлэлцүүлэгт орж байна. Энэ чинь өөрөө бас нэг энэ цаг хугацааг алдуулж байна гэдэг чинь нэг зүйлийг хэлээд байгаа юм. 4 сар болж байж одоо энэ хууль анхныхаа хэлэлцүүлэгт орж байна. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцээд явах нь зүйтэй.

Гэхдээ нөгөө парламентын буюу 126 гишүүнтэй 4 нам, 1 эвсэлтэй энэ субъектүүдийнхээ оролцоог хэрхэн хангах вэ гэдэг дээр нь нарийн зохицуулалтууд нэмж өгмөөр байгаа юм. Тухайлбал Их Хурлын дарга нам бус боллоо, тэгээд хэн нэгэн Их Хурлын гишүүн хууль санаачлах эрх бүхий этгээд хуулийн төсөл оруулж ирэхэд тэрийг хэлэлцүүлэгт тэд хоногийн дотор оруулж байна гэдэг зүйл ч гэсэн нэммээр байгаа байхгүй юу. Бид чинь Засаг захиргааны энэ байгууллагууд 30 хоногийн дотор иргэдийн хүсэлт шаардлагад хариу өгч байх үүрэгтэй шүү дээ. Бид

өөрсдөө иргэдийн төлөөлөл гээд, хууль санаачлах эрхээ хэрэгжүүлээд оруулахаар тэр нь удчихдаг, хэзээ хэлэлцэх нь мэдэгддэггүй. Пүрэвдорж гишүүн тэр Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөл дээр 6 билүү, 8 хууль оруулаад 2 нь хэлэлцэгдээд, бусад нь хэлэлцэгдэхгүй. Үгүй ээ Их Хурлын дэд дарга хууль оруулаад 2 жил, 3 жил хэлэлцүүлж чадахгүй яваад л байна шүү дээ. Тийм зүйл яриад л байсан. Тэгэхээр энэ зүйлүүдээ нэмж хиймээр байгаа юм.

Тэгээд эргээд асуудал ярихаар хуульд ийм юм чинь одоо яах юм бэ гэдэг. Хуулийг нь авч хэлэлцүүлэгт оруулахгүй байхаар яаж тэр чинь явах юм. Тэгэхээр ийм зүйлүүдээ ажлын хэсэг байгуулж нэмэх нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд Бямбацогт дарга Их Хурлын дарга болчихвол энэ зүйлүүд дээр анхаарч, 5 намын төлөөллөөс яах вэ тэр суудлын тоо их, багадаа биш, ер нь тэнцүү төлөөлөлтэй оруулж байгаад нэг ярьчихмаар байгаа юм шүү дээ. Агуулга, нөгөө санал хураахдаа тэр хураалт дээр их, багаараа ялгардаг л юм байгаа юм биз. Үзэл санаа дээр нь тэгээд хамтраад ажиллачихмаар байна гэдгийг хэлмээр байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Батбаатар гишүүнээ ийм шүү дээ, 11 сарын 25-нд өргөн баригдсан энэ хууль тухайн үед 5.7-гоор, Дэгийн тухай хуулийн 5.7-гоор хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулъя гээд, тэгээд 5.7 нь дэмжигдээгүй уначихсан байхгүй юу. Тэгээд намрын чуулган дуусаад, одоо хаврын чуулган эхэлж байгаа учраас хаврын чуулганаар ингээд хэлэлцэх эсэхийг нь хийгээд явж байгаа нь энэ шүү. Тэгэхгүй бол 4 сар хүлээлгээд ингэж байна гэж буруу ойлгож, тайлбарлаж болохгүй. Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Энэ хуулийн үзэл санааг дэмжиж байгаа. Би нэг сүүлийн үед Төрийн өндөр албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хамгаалалт, хязгаарлалт, хяналт, хариуцлага тооцох тухай хууль гээд яриад яваад байгаа. Нийтдээ энэ чинь 20 гаруй хуулийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт, 2 хууль шинээр өргөн барих нэлээн томоохон багц хууль явж байгаа. Тэгээд хязгаарлалт гэдэг эрх зүйн ойлголтын хүрээнд энэ хуулийн үзэл баримтлалд нийцэж байгаа. Ер нь энэ хуулийн үзэл санаа Зандаахүүгийн Энхболдын үед ч яригдаж байсан, огт хэрэгжээгүй. Миеэгомбын Энхболдын үед ч яригдсан, хэрэгжээгүй. Ингээд Занданшатар, Амарбаясгалан гээд явсан. 25 оны 5 сард байх Баярмаа гишүүнээ, Амарбаясгалангаар ахлуулсан Их Хурлын гишүүдийн бүрэлдэхүүн Англи улсад айлчилсан. Тэгээд энэ айлчлалын үр дүнд бид ерөөсөө энэ хуулийг одоо бол эрчтэй явуулах ёстой юм байна гэж анх ярьсан. Тэмүүжин гишүүн энэ бүрэлдэхүүнд явж байсан, АН-аас Баярмаа гишүүн явж байсан. Тэгээд энэ маань ингээд биеллээ олох зам дээрээ ирж байна.

Энийг зэрэгцээд Бямбацогт даргаа та бас энийг хариуцлагатай сонсмоор байна. Та хоёр тэр улс төрийнхөө найруулгаа дараа ярьчих. Үгүй ээ үгүй нээрээ шүү дээ. Яагаад гэхээр одоо анзаар, Бүлгийн дарга нь гараад явчихсан, нэр дэвшигч нь энд ерөөсөө ач холбогдол өгч байгаа юм байхгүй. Өөрөөр хэлбэл энэ хууль нохойн замаар орно шүү. Гантөмөр даргын хэлээд байгаа чинь үнэн шүү дээ. Ажлын хэсэг байгуулъя, нарийн ширийн судалъя, энэ бол зүгээр аргадах заль байхгүй юу. Би мэднэ шүү дээ, энэ залийн чинь author нь би өөрөө шүү дээ, тийм биз дээ Бямбацогт даргаа. Та бид 2 яадаг байлаа, энэ бол худлаа шүү. Тэгэхээр одоо нэгмөсөн хариуцлагатай эндээ тохчихмоор байгаа байхгүй юу.

Тэгээд АН-ынхандаа ч гэсэн хэлэхэд битгий ингээд нэг иймэрхүү асуудал болж байхад Ардын намын дарга нарын өрөөгөөр гүйгээд, ганц нэг 100 горьдоод

яваад бай, болохгүй шүү. Яг энэ хууль дээр хатуу байх хэрэгтэй. Ний нуугүй л хэлье. Нэрийг нь энэ удаа хэлэхээ орхичихъё, хатуу байгаад энэ нэг явчих хэрэгтэй. Тэрнээс биш нэг их өргөжүүлнэ, иймэрхүү, иймэрхүү, Шижирээ чи дуугүй байгаарай, өргөжүүлээд ингээд наадах чинь ингээд унтуулах арга зам руугаа орох гээд байна. Тэгэхээр Бямбацогт дарга та энэ өөрөө байна шүү дээ ардчилсан парламентын засаглалтай Монголын төрийн түүхэнд нэг том түүхэн milestone гэдэг цэг байхгүй юу энэ. Энэ өөрөө маш том түүхийн нэг эргэлт болно. Тэгэхээр энэ дээр та өөрөө манлайлагч байх хэрэгтэй байна. Тэрнээс биш ингээд аргацаагаад унтуулаад, нэг л их ажлын хэсэг яриад, нарийн ширийн судална гээд байх хэрэггүй. Аягүй тодорхой байгаа. Тэмүүжин гишүүний энэ хууль дээр анх санаачлагчдынх нь нэг би гарын үсэг зурсан уу, үгүй билүү санахгүй байна. Бүрэн дэмжиж байгаа энийг. Бүгдээрээ дэмжээд, нэн яаралтай энийг хэлэлцээд явсан нь дээр. Ийм байр суурь илэрхийлье.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би энэ үг хэлж байгаа намын дарга нартай бол санал нэг байна. 1 дүгээрт би Номтойбаяртай санал нэг байна, Гантөмөртэй санал нэг байна. Ер нь ингээд нөгөө хуурах ажиллагаа байнга явдаг учраас нэгэндээ ингээд итгэхгүй болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр энэ агуулгаараа нөгөө эр хүн хэлсэндээ гээд л та нар улс төрийг эр хүн, эрчүүд л хийдэг юм шиг ийм ойлголт төрүүлж болохгүй. Ер нь хэлсэн ярьсандаа байх хэрэгтэй.

Би зүгээр нэг юм залруулж хэлэх гээд байгаа юм нь юу вэ гэхлээр 1 дүгээрт нөгөө ҮХЦ-ийн сая Ерөнхий сайдыг огцруулахтай холбоотой энэ хоногийн асуудлаар 7 юу, 10 уу гээд Үндсэн хууль болон Дэгийн хуулийн зөрчилтэй холбоотой Бямбацогт сайдыг тухайн үед ажлын хэсгийг ахалсан гэж хэлсэн. Тэгээд би энийг одоо залруулж хэлэх ёстой. Энэ бол Бямбацогт гишүүн ахлаагүй гэдгийг би энд залруулж хэлье.

Учир нь гэвэл нь 2020 оны 4 сарын 24-ний өдөр Лүндээжанцан гишүүд нарын 8 гишүүн тус хуулиудыг өргөн барьж, Ж.Мөнхбат гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг 4 сарын 28-ны өдөр, 2020 оны 4 сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын 5 дугаар тогтоолоор зохион томилогдож, ингээд энэ хуулиуд 20 оны 5 сарын 19-ний өдөр батлагдсан байдаг юм. Тэгэхээр яг энэ 20 оны 5 сард батлагдсан энэ хуулиудаар тухайн Улсын Их Хурлын даргыг ямар нэгэн асуулт, саналгүйгээр шууд олонхоор сонгох гэсэн ийм өөрчлөлтийг 20 онд хийсэн байдаг юм. Тэгэхээр энэ бол ойрын асуудал биш, 20 онд энэ хуулийн өөрчлөлтийг хийсэн гэдгийг цохон тэмдэглэе. Тэгэхээр би үүгээрээ юу хэлэх гээд байна вэ гэхлээр ер нь гишүүд хуулиа сайн уншиж, нөгөө сайн цаад агуулгаар нь бусад харилцаа холбоог нь харахгүйгээр л ингээд батлаад, батлаад явчихдаг нь өөрөө эргээд л нөгөө энэ улс төрийн шахалт, улс төрийн нөхцөл байдлууд байдаг байх л даа.

Тэгэхээр энэ агуулгаар энэ хуулийг бол дэмжиж байгаа. Энийг гэхдээ шууд маш яаралтайгаар өнөө маргаашгүй батална гэдэг нь өөрөө алдаа дутагдалтай гарчхаж магадгүй гэсэн ийм зовнил бол байгаа. Тэгэхээр 1 дүгээрт, яг энэ Улсын Их Хурлын бид чинь парламентын засаглалыг л бэхжүүлэх гээд байгаа гэдэг энэ чин хүсэлтэй байгаа гэдэг дээр бол бид Тэмүүжин гишүүнтэй бол би үүн дээр байнга санал нийлж ингээд явдаг. Тэгээд энэ хуулийг Улсын Их Хурлын тухай хууль дээр 11.1 дээр нь олонх Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ гэж өөрчлөн найруулсан байна. Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр нь болохлоор 19.1 дээр Улсын Их

Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу олонх Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ гээд ингээд хаачихсан байгаад байгаа байхгүй юу.

Өмнөх, одоогийн байгаа зохицуулалт нь өөрөө юу юм бэ гэхлээр олонх нэр дэвшүүлнэ. Хэрэвзээ олонх бүрдэж чадаагүй бол эвсэл дэвшүүлнэ, бүүр одоо болохгүй бол гээд ийм олон гарцуудтай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ агуулгаараа зөвхөн олонх дэвшүүлнэ гээд ингээд орхичихлоор цааш цаашдаа парламентын засаглал, бид ингээд л маш их тэмцэлтэй, маш их хэрүүлтэй ийм байгаа цагт намуудын нэр хүнд ч гэсэн ер нь бол унаад байгаа. Цаашдаа яг 126 гишүүнтэй 64 гишүүнтэй нэг нам шууд олонхыг бүрдүүлж чадахгүй байвал яах вэ гэдэг энэ агуулгууд чинь яг энэ хуулийн өөрчлөлтөөр бол бас орхигдчихсон байна шүү гэдгийг сануулъя. Дараад нь хуулиараа эвсэл байгуулагдвал, эсхүл одоо яах вэ гэдэг агуулгууд орхигдоод, Улсын Их Хурлын даргаа дэвшүүлж чадахгүй нөхцөл байдал үүсэх вий нэг.

2 дахь нь болохлоор Ерөнхий сайдыг бол бид хуралдаанд оролцсон гишүүдийнхээ олонхоор сонгочихдог, огцруулахдаа нийт гишүүдийн олонхоор. Гэтэл одоо Улсын Их Хурлын даргыгаа бол эсрэгээрээ гишүүдийн олонхоор одоо томилох гээд байгаа нь.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе. Энэ хуулийг зарчмын хүрээнд дэмжих ёстой. Энэ хуулийг ярихдаа өнөөдөр маргаашийн улс төр намчирхмааргүй байгаа юм. Хамгийн намчирхах ёсгүй бараг Үндсэн хууль баталж байгаа хэмжээний, Үндсэн хууль авч үзэж байгаа хэмжээний авч үзэх ёстой зарчим нь энд хууль дотор яваад байна л даа. Тэгэхээр бидний Монголд өнөөдөр тохиолдож байгаа үйл процессыг бид заавал авч үзэх ёстой юм. 2 зүйл хэлмээр байна.

1 дүгээрт, 2024 оны эдийн засгийн Нобелийн шагнал авсан 2 профессор байгаа юм MIT-ийн Acemoglu, Robinson гээд. Ер нь Монгол шиг хөгжиж байгаа орнуудын хөгждөггүй үндсэн шалтгаан нь ерөөсөө улс төр болон эдийн засгийн институцийн сул байдлаас болж бид хөгждөггүй юм гээд. Бид өнөөдөр авлига хээл хахууль асуудал нь юм шиг байгаа юм, авлига хээл хахууль нь хам шинж нь байхгүй юу. Үндсэн шалтгаан нь институц бие даасан байдлууд хоорондоо зөрчилдөөд, бие даасан байдлаа хадгалж чадахгүй байгаа институцээ сул байлгаснаас болоод бидний хөгжлийн гацаа нь өнөөг хүртэл явж ирсэн энэ 30 жилийн түүх юм.

2 дугаарт, Монгол Улс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулж өнөөдрийн болж байгаа энэ их улс төржилт, энэ 76-аас 126 руу шилжсэн системийн шилжилт хийсэн. Системийн шилжилт хийгээд шинэ систем гарч ирэхэд заавал реакциуд гарч ирдэг. Гэхдээ 126 болсноороо өнөөдөр жишээлбэл сая Батбаатар дарга зөв үг хэлж байна л даа. Бид олон намын тогтолцоо ороод ирчихсэн байхгүй юу, 5 намаас цаашаага бид улам ингээд солонгороод явна. Ер нь нэг нам давамгайлсан тогтолцоо бараг эндээс цаашаа бараг байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ үед систем илүү бэхжих энэ боломж олдож байгаа энэ үед УИХ буюу парламентын ардчилалтай ардчилал давамгайлсан, парламентын ардчилалтай орны парламент нь өөрөө бие даасан байдлаа илүү бэхжүүлж авах ёстой. Энэ бол бүүр 1 дүгээрт тавигдах ёстой зүйл.

Тэгэхээр парламентын ардчилал бэхжихэд яг энийг зохион байгуулж байгаа спикер өөрөө бие даасан байх ёстой, neutral байх ёстой. Олон улсад зөндөө жишгүүд байгаа. Ер нь аль ч экстрим жишгийг аваад буруу, зөв юм шиг ярьж болно. Гэхдээ тэнд үндсэн зарч нь neutral гэж үг байгаа юм neutrality. Энэ нь нэг ёсондоо бие даасан, төвийг сахисан байх ёстой гэдэг сая энэ хуулийн зарчим дээр тулсан байна. Энэ байдал байхгүй бол бид 5-аас олон нам цаашаага гарч ирэхэд тэр намуудын бие даасан байдлыг, тэр намуудын дуу хоолойг УИХ дээр заавал хүргэж ингэж Улсын Их Хурлын ялангуяа парламентын бие даасан институцийн байдлыг улам бэхжүүлж явах ёстой юм. Тийм учраас энэ хуулийг зарчмын хувьд дэмжинэ.

Энэ дотор бас нэг зүйлийг хэлмээр байна. Парламентын ажлын 50 хувь нь хяналт механизм шүү. Хяналт механизмын зүг хэрэгжүүлэх, хяналт механизмын хамгийн одоо том жишиг нь Хянан шалгах түр хороо байсан. Тэгэхээр энэ хяналтын механизм парламент дээр ажиллахад тэрийг баталж өгч байгаа Улсын Их Хурлын дарга нь бие даасан байх нь маш чухал шүү. Тэгэхгүй бол аль нэг нам эсвэл давамгайлж байгаа нам хэт хяналтын механизмыг өөртөө давуу байдлаар ашиглаж, институцийг улам сулруулах ийм процесс явдаг. Тийм учраас хяналтын механизм нь уул нь 30 жил ажиллах ёстой байсан. Гэхдээ бидэнд одоохондоо ер нь шинэ л явж байгаа. Энэ цаашаа улам төгөлдөржиж явах ёстой. Энэ Монгол Улсад цаашдаа улс төрийн институц бэхжүүлэхэд маш том үүрэг role-той болно. Тийм учраас энэ хууль заавал явах ёстой. Өнөөдрийн улс төрийн нэг гацааг гаргаад, зүгээр нэг хэлэлцэхийг нь дэмжээд үлдэж болохгүй шүү. 126 гишүүнтэй парламентын өв болж үлдэх ёстой цөөхөн хуулийн нэг энэ шүү гэж хэлмээр байгаа юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Өглөөний мэнд бид бүхэн Үндсэн хуулиа дагаж, хуулиудаа өөрчилж, шинэчилж сайжруулах ёстой байгаа. Тэгээд Үндсэн хуульд болохоор улс төрийн намын оролцоо төрийн байгууллын 4 институцийн 3 дээр нь нэр дэвшүүлэхэд л оролцох ийм тодорхой зохицуулалтууд байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал гэдэг байгууллын хувьд бол дэд даргыг нэр дэвшүүлэхэд, томилоход, ЗГ Ерөнхий сайдыг томилоход, Ерөнхийлөгчид парламентад суудалтай намуудаас нэр дэвшүүлэх, өөрөөр хэлбэл нэр дэвшүүлэх үйл ажиллагаагаар энэ төрийн байгуулал Үндсэн хуулийн энэ үйл ажиллагаанд оролцоо нь ингээд хязгаарлагдаж байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүд ард түмний төлөөлөгч байх ёстой. Гэтэл илүү зүгээр сайжруулах ёстой нэг зүйл нь болохоор энэ намын бүлгүүд дээр нам төр дээр гарчихсаныг жишээлбэл зөвхөн энэ Улсын Их Хурлын даргын үйл ажиллагаагаар биш, намын бүлгүүд дээр жишээлбэл аль ч намын бүлгүүд ялгаагүй адилхан Улсын Их Хурлын гишүүдийн энэ ард түмний элч төлөөлөгч байх эрхийг нь хязгаарлаж байгаа юм. Одоо 1 одтой, 2 одтой, 3 одтой ч гэдэг юм уу АН-ынхан маань, юу Ардын нам дээр ч гэсэн тодорхой шийдвэрүүд дээр намын бүлгээс тодорхой шийдвэрүүд гарч, Улсын Их Хурлын гишүүдийн санал өгөх эрхийг нь улс төрийн намууд шийдэж хязгаарлаж байгаа, намын бүлгээрээ дамжуулж шийдвэрлэж хязгаарлаж байгаа иймэрхүү үйл ажиллагаанууд байгаа. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцэхийн хувьд зарчмын хувьд дэмжиж байгаа юм.

Тэгээд энэ хуулийг өнгөрсөн оны 10 сард энэ хуультай холбогдуулж практик хүндрэлүүд гарсан учраас энэ хуультай холбогдуулж судалгаа хийгээд хуулийн төсөл бичиж байсан юм. Тэгээд тэр үед болохоор нэг гишүүн ч юм уу, нэг улс төрийн нам энэ төслийг боловсруулахад хэцүү юм байна гээд өнгөрсөн оны 10 сард

Булгантуяа даргад ажлын хэсэг байгуулж өгөөч, бусад намуудын төлөөллийг ороод, судлаачдыг оруулаад, тэрнийхээ үндсэн дээрээс судлаад шаардлагатай хуулийн төсөл боловсруулъя гэдэг саналыг тавьж байсан. Тэгээд тэр үед шийдээгүй. Тэгэхээр манай зарим гишүүд энэ парламент гэхээр нэг хүн дарга нь байхаар таньдаг ч юм уу, найз нь ч юм уу эсвэл бүлгийнх нь холбоотой хүн нь дарга болохоор нэг асуудал ярьдаг, тэр нь болингуут өөр юм ярьдгаа болимоор байна.

Бид Улсын Их Хурлын чуулган дээр Алд бие минь алжааваас алжаатугай ахуй төр минь бүү алдартугай гэдэг үг байдаг. Энэний цаад утга нь бол нэг хүн дагаж намирдаг биш, хүнээс хамаардаггүй институц та хэд бий болго гэдэг юмыг бид толгой дээрээ залчхаад харж байгаа юм. Тэгэхээр улс төрийн намууд маань өөрөө бие даасан ардчилсан ч юм уу, энэ зарчмууд одоо төлөвших шатанд, би хангалттай болж чадаагүй гэж бодож байна аль ч намуудын хувьд. 1 даргаас хамаарсан, ийм хэсэг бүлгээс хамаарсан бүтцүүд байсаар байна. Тэрнийхээ зовлондоо одоо идэгдэж байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд маань ч гэсэн яг энэ Үндсэн хуулийн суурь зарчмаа барьж өөрчлөх чиглэл рүү ажиллаасай гэж бодож байна. Тэгэхээр энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Эхнээс нь энийг судлуулахаар санал хүсэлт гаргаж байсан, дэмжинэ. Улсын Их Хурлын гишүүдийг ч гэсэн сайн тунгааж бодоорой гэж хэлмээр байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: 1 гишүүний дараа санал хураалт явуулна, гишүүдийг дуудаарай. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд шуурхай хэлэлцээд, энэ парламентын ардчиллыг бэхжүүлэх чиглэлд энэ хууль чухал гэдэг дээр дэмжиж үг хэлж байна. Тэгээд би зүгээр Бямбацогт даргад л хандаж үг хэлэх гэж байгаа юм. Ингээд Хурлын дарга болбол танд туршлага, мэдлэг, харизм байна, тодорхой манлайллыг авч яваач. Таны гарт нэлээн энэ парламентын ардчиллыг бэхжүүлэх чиглэлд энэ түүхэн цаг үе ирлээ. 2 жил парламент маань үндсэндээ хэрэлдлээ. Хэдүүлээ одоо энэ хэрүүл тэмцлээ ер нь зогсоогоод, яг энэ парламентын сүүлийн 2 жил дээр ямар өв үлдээх вэ гэдэг зүйлийг л илүү бодож анхаараасай гэж бодож байна. Би зүгээр яг Байнгын хорооны түвшинд МАН-аас гадна бусад намуудын дарга нар байж байна. Номтойбаяр дарга байж байна, Гантөмөр дарга байж байна, Батбаатар дарга байж байна, Доржханд дарга байж байна. Энэ зөвхөн энэ спикерийн асуудлаасаа гадна энэ ҮХЦ байдаг юм уу, энэ төрийн байгуулалттай холбоотой хууль, эрх зүйн орчнуудаа хэдүүлээ нэг яах аргагүй мэтгэлцэж, зөвшилцөөд ер нь нэг шийдье.

Тэгэхгүй ингээд олон жил угаасаа ингээд болохгүй, процессгүй байгаа энэ хуулиудыг зүтгүүлж явсаар байтал сүүлдээ энэ институц хоорондынхоо мөн чанарыг эвдэж дуусах нь. Тийм учраас одоо энэ парламентын гол чухал асуудал энэ юм. Тэгээд энэ төрийн байгууламж гэдэг юм уу, төрийн үйл ажиллагаа энэ улс төржихгүй, ийм процесс нь ил тод болоод ирвэл энэ нийгэм, эдийн засгийн амьдралууд ч гэсэн шийдэгдээд ирнэ. Энэ улс төржихийн хэрээр иргэд ядуурч байна, улс төржихийн хэрээр энэ төрийн алба хүнд суртал нь нэмэгдэж байна, улс төржихийн хэрээр энэ төрийн албан дахь назгайрал ийм хүнд суртлууд ихсэж байна, улс төржихийн хэрээр энэ иргэдийн орлого буурч байна шүү дээ. Тийм учраас энэ эдийн засгийг өөд нь татъя гэвэл төр өөрөө, өөрөө өөрийнхөө энэ үйл ажиллагааг журамлаж байгаа хууль, эрх зүйн орчнуудаа маш тодорхой болгоод өгчихмөөр

байна. Энэ дээр Бямбацогт сайдыг, Бямбацогт даргыг Улсын Их Хурлын дарга болбол яаралтай ажлын хэсэг зөвшилцлийн гэнэ үү, юу нь вэ мэдэхгүй байна. Энэ тал талын төлөөллийг гаргаад, төрийн байгууллагын хууль тогтоох энэ ингээд явж байна, гүйцэтгэх, эргээд энэ Ерөнхийлөгчийн институцийн, ингээд ҮХЦ-ийн энэ бүх хууль, эрх зүйн орчнууд дээр хэдүүлээ нэг дүгнэлт өгөөд, энэ хувилбарууд байна. Тэгээд энэ Хууль зүйн байнгын хороотойгоо нэг хамтарсан ажлын хэсэг гаргаад гишүүдээс нь яваач. Би бас боломж байдаг бол ажлын хэсэгт орж ажилламаар байна. Тэгээд энийг нэг шийдмээр байна.

Тэгээд намын дарга нар байгаа учраас би энэ уриалгыг хүргүүлж байна. Та хэд маань улс төрийн leadership-ээ харуулаад шахаж шаардаач. Ингээд маш богино хугацаанд энэ нэг зөвшилцөл гэдэг юм уу, энэ зүйлүүд шийдэгдэж байж энэ улс орны эдийн засаг цэгцтэй шийдвэрүүд гарна. Бид хэд үнэндээ хэлэхэд энэ улс төр нь дээрээ бужигнаад байхаар энэ эдийн засаг, хөрөнгө оруулалт угаасаа орж ирэхгүй. Угаасаа энэ эдийн засгийг идэвхжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлууд үүсчхэж байгаа байхгүй юу улс төр талаасаа. Тийм учраас энэ зүйлүүдээ нэг хэдүүлээ нэг анхаараад, маш шуурхай ажиллахыг улс төрийн намын дарга нараасаа, ТББХ-ны гишүүдээсээ, тэгээд болдог бол энэ дээр ХЗБХ-г оруулаач. Тэгээд ингээд хамтраад, шуурхай ажиллая л гэсэн ийм уриалгыг дэвшүүлж байна. Тэгээд Бямбацогт сайд Хурлын дарга болбол энэ дээр шуурхай арга хэмжээ авч өгөөрэй гэж хүсэлт байна.

Ц.Сандаг-Очир: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан, үгээ, дуусчихсан шүү дээ? Тийм. Одоо чуулган эхэлчихсэн учраас гишүүд уг нь эртхэн ирээд үгэндээ орчихсон олон гишүүд байна. Тэгээд хаачихсан учраас дэгээ барья хэдүүлээ. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. 4 санал хураалттай, саналын томьёоллыг уншъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 23 гишүүнээс 19 гишүүн дэмжиж, 82,6 хувиар санал дэмжигдлээ. Протоколд Пүрэвдорж гишүүнийг дэмжсэнд тооцоорой.

2 хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 23 гишүүнээс 18 гишүүн дэмжиж, 78,3 хувиар санал дэмжигдлээ. Протоколд Пүрэвдорж гишүүнийг дэмжсэнд тооцуулаарай.

Хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүн дэмжиж, 78,3 хувиар санал дэмжигдлээ. Пүрэвдорж гишүүнийг протоколд дэмжсэнээр оруулаарай.

Хамт өргөн мэдүүлсэн Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүн дэмжиж, 78,3 хувиар санал дэмжигдлээ. Пүрэвдорж гишүүнийг дэмжсэнд тооцоорой.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг ТББХ хийж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Идэрбат танилцуулна.

10.37 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА